

# Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development

Second edition

# Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томъёоны тайлбар толь

2 дахь хэвлэл

English/Mongolian



This work is published under the responsibility of the Secretary-General of the OECD. The opinions expressed and arguments employed herein do not necessarily reflect the official views of the OECD Members.

Originally published by the OECD under the title: OECD (2023), Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development (Second Edition), OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/632da462-en-fr-es>

The only official versions are the English and/or French texts. In the event of any discrepancy between the original work and the translation, only the text of the original work should be considered valid.

© 2024 OECD / the MERIT Project for this language edition.

Please cite this publication as: OECD (2023), Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development (Second edition), OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/82fbdfda-en-mn>

Mongolia: Enhancing Resource Management through Institutional Transformation (MERIT) is an eight-year project (2016-2024) funded by the Government of Canada and implemented by Catalyste+. MERIT is a governance project that supports sustainable management of the resource sector. It strengthens the capacity of government and encourages inclusive economic and social development.

“Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development” was translated into Mongolian with the support of the MERIT project.

Энэхүү бүтээлийг ЭЗХАХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагын хүрээнд эрхлэн хэвлүүлэв. Үүнд дурдагдсан санаа, үзэл бодол нь ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Тус бүтээлийг ЭЗХАХБ-аас “OECD (2023), Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development (Second Edition), OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/632da462-en-fr-es> нэрээр нийтэлсэн.

Бүтээлийн албан ёсны хувилбар нь Англи болон Франц хэл дээрх хувилбар болно. Эх бүтээл болон орчуулгын хооронд зөрүү гарсан тохиолдолд зөвхөн албан ёсны хувилбарыг хүчинтэйд тооцно.

© 2024 OECD / МЭРИТ төслөөс Монгол хэлнээ орчуулан, хэвлүүлэв.

Энэхүү бүтээлийг доорх байдлаар эш татах боломжтой: OECD (2023), Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development (Second edition), OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/82fbdfda-en-mn>

Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй, Канадын Мэргэжлийн Үйлчилгээний Байгууллагын төлөөлөгчийн газраас “Монгол улс: Институцийн өөрчлөлтөөр дамжуулан эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төслийг хэрэгжүүлж байна. Төсөл нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах замаар олборлох салбарын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор 2016 – 2024 оны хооронд үргэлжилнэ.

“Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томьёоны тайлбар толь” –ийг MERIT төслийн дэмжлэгтэйгээр эмхэтгэн боловсруулав.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР



УАИРЛАЛГЫН  
АКАДЕМИ



# Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development

Second edition

# Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томъёоны тайлбар толь

2 дахь хэвлэл

2024

ISBN 978-92-64-38930-4



# Foreword

In 2002, the Organization for Cooperation and Economic Development (OECD), with the Development Assistance Committee (DAC)'s Working Party on Aid Evaluation (WP-EV) first published a glossary of key terms in evaluation and results-based management for planners and evaluators. Since then, based on the experience gained over the past 20 years, the organization has developed a revised version of the glossary in English, French and Spanish and published it for international use in June 2023.

To advance government transparency, strengthen the evaluation system, and enhance collaborative efforts to improve efficiency, it is essential for Mongolian public servants, similar to other countries, to have a common understanding of the terminology of evaluation and results-based management. The MERIT project, funded by the Government of Canada and implemented by Catalyste+, supports initiatives and activities to mainstream results-based management in Mongolia. It works closely with the Cabinet Secretariat of the Government of Mongolia and the National Academy of Governance. One result, achieved through a multi-stakeholder collaborative process, is the translation of this glossary of terms into Mongolian. The MERIT project is honored to support this initiative and to publish the OECD glossary in Mongolian.

An Explanation of Key Terms in Sustainable Development, Evaluation and Results-Based Management is a practical reference book aimed at building common understanding, interdisciplinary dialogue and capacity building among government officials working in monitoring and evaluation. It will be a valuable guidance for the sector professionals and decision makers on how to implement the legislation and fulfill their responsibilities related to planning, monitoring and evaluation. We are delighted to provide you with commonly agreed upon terms and their translations in this glossary.

# ӨМНӨХ ҮГ

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Хөгжлийн тусламжийн хорооны Тусламжийн үнэлгээний ажлын хэсэг хамтран Төлөвлөлт, үнэлгээ хариуцсан ажилтнуудад зориулсан “Үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томьёо”-ны тайлбар толийг анх 2002 онд олны хүртээл болгосон. Улмаар тус байгууллагаас өнгөрсөн 20 жилийн хугацаанд бий болсон туршлагад тулгуурлан тайлбар толийг шинэчлэн Англи, Франц, Испани хэлнээ 2023 оны 6 дугаар сард нийтэлж олон улсын хэрэглээнд орууллаа.

Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдал, үнэлгээний тогтолцоог төгөлдөржүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах нэгдмэл хүчин чармайлтаа нэмэгдүүлэх үүднээс Монгол Улс бусад орнуудын нэгэн адилаар үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын нэр томьёоны талаар нэгдсэн ойлголттой болох зайлшгүй шаардлагатай юм. Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй MERIT төсөл нь Үр дүнд суурилсан удирдлагыг Монгол улсад нэвтрүүлэх санаачилга, үйл ажиллагааг дэмжиж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Удирдлагын академитай нягт хамтран ажиллаж ирсэн. Үүний үр дүнгийн нэгээхэн хэсэг нь энэхүү нэр томьёоны тайлбар толийг Монгол хэлнээ хөрвүүлэхэд олон талт хамтын оролцоотойгоор ажилласан явдал юм. MERIT төслийн хувьд энэхүү санаачилгыг дэмжиж, тайлбар толийг Монгол хэлнээ нийтэлж буй нь нэр төрийн хэрэг юм.

Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томьёоны тайлбар нь мониторинг, үнэлгээний чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын дунд нэгдсэн ойлголт бий болгох, салбар дундын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, чадавхыг сайжруулахад чиглэсэн практик лавлагаа билээ. Энэ нь салбарын мэргэжилтнүүд болон шийдвэр гаргагчдад төлөвлөлт, мониторинг, үнэлгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ажил үүргээ гүйцэтгэхэд нь үнэ цэнтэй удирдамж болох юм.



# Acknowledgements

On 2017, 15 years after the first version of this OECD glossary of terms was published internationally, Professor **Bold Nergui** of the National Academy of Governance (NAoG) of Mongolia sought to offer a version which would include the Mongolian translation of terms and definitions. This work is largely due to his efforts and vision.

The invaluable contribution of MERIT's Senior Technical Advisor, **Raymond Gervais**, whose vision and process for the translation of the glossary led to a common understanding among the stakeholders. This glossary provides guidance and mainstreaming of results-based management in Mongolia.

Furthermore, special thanks to the staff of the **Cabinet Secretariat of the Government of Mongolia, the Agency of Government Supervisory, the National Academy of Governance and the Mongolian Evaluation Association**, who showed management leadership and ensured a high level of participation in developing the definition of terms.

In addition, sincere gratitude to all stakeholders who worked together to develop this glossary, have it translated, and to build consensus through discussion. They include:

- Civil Service Council
- Ministry of Economy and Development
- Ministry of Road and Transport Development
- The National Academy of Governance
- Dornod Province Governor's Office
- Dundgovi Province Governor's Office
- Sukhbaatar Province Governor's Office
- Tuv Province Governor's Office
- United Nations Development Program
- UNDP- "SDG-aligned budgeting to transform employment in Mongolia" project
- UNICEF
- Independent Research Institute of Mongolia



# Талархал

Энэхүү нэр томъёоны тайлбар толийн анхны хувилбар Олон улсад хэвлэгдэн гарснаас 15 жилийн дараа буюу 2017 онд Удирдлагын Академийн профессор **Нэргүйн Болд** Монгол хэлнээ орчуулсан хувилбарыг гаргах санаачилгыг эхлүүлэн үйл хэрэг болгосон нь түүний алсын хараа, хичээл зүтгэлийн үр дүн юм. Тайлбар толийг боловсруулах, нэгдсэн ойлголтод хүрэх, гарын авлагын практик ач холбогдлыг оролцогч талуудад ойлгуулах, үр дүнд суурилсан удирдлагыг Монгол улсад нэвтрүүлэхэд MERIT төслийн Техникийн ахлах зөвлөх **Рэймонд Жервэйсийн** үнэлж баршгүй хувь нэмрийг онцолж хэлэхэд таатай байна.

Түүнчлэн нэр томъёоны тайлбарыг боловсруулж, нийтийн хүртээл болгоход удирдлагын манлайлал үзүүлж, оролцоог өндөр түвшинд хангаж ажилласан Монгол Улсын **Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Удирдлагын академи, Монголын үнэлгээний холбооны** хамт олонд онцгойлон талархал илэрхийлье.

Мөн энэхүү тайлбар толийг боловсруулахад хамтран ажиллаж, орчуулах, хэлэлцүүлэг өрнүүлж нэгдсэн зөвшилцөлд хүрэхэд гар бие оролцож, үнэтэй хувь нэмрээ оруулсан бүх оролцогч талууддаа гүн талархал илэрхийлье. Үүнд:

- Төрийн албаны зөвлөл
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Зам, тээврийн хөгжлийн яам
- Удирдлагын академи
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар
- Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар
- Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар
- Төв аймгийн Засаг даргын тамгын газар
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
- НҮБ-ын Хүүхдийн Сан
- Хараат Бус Судалгааны Хүрээлэн

## Table of contents

### Terms grouped by categories

#### Concepts, data and tools

- 18 Accountability
- 18 (Community) Accountability
- 19 (Mutual) Accountability
- 20 Additionality
- 20 Administrative data
- 20 Analytical tool
- 21 Appraisal
- 22 Attribution
- 22 Audit
- 24 Causality
- 25 Context
- 26 Contribution
- 26 Control group
- 26 Counterfactual
- 27 Culture of results and learning; Culture of evaluation
- 27 Data collection tool
- 28 Economic
- 29 Economical
- 31 Evaluability
- 31 Evaluand
- 31 Evaluation
- 32 Evidence
- 32 Evidence-based (policy, practice)
- 34 Finding

## Гарчиг

### Ангилалаар бүлэглэсэн нэр томьёо

#### Ойлголтууд, өгөгдөл, хэрэгслүүд

- 18 Эгэх хариуцлага
- 18 Эгэх хариуцлага (иргэдийн өмнө хүлээх)
- 19 Эгэх хариуцлага (хамтын)
- 20 Нэмэгдэл
- 20 Захиргааны өгөгдөл
- 20 Шинжилгээний арга хэрэгсэл
- 21 Урьдчилсан үнэлгээ
- 22 Атрибют
- 22 Аудит
- 24 Шалтгаан үр нөлөө
- 25 Нөхцөл байдал
- 26 Хувь нэмэр
- 26 Хяналтын бүлэг
- 26 Эсрэгцүүлэх баримт
- 27 Үр дүн ба сайжруулан суралцах соёл; Үнэлгээний соёл
- 27 Өгөгдөл цуглуулах хэрэгсэл
- 28 Хэмнэлт
- 29 Хэмнэлттэй байх
- 31 Үнэлэгдэх боломж
- 31 Үнэлгээний объект
- 31 Үнэлгээ
- 32 Нотолгоо
- 32 Нотолгоонд суурилсан (бодлого, практик)
- 34 Олдвор

- 34 Gender analysis
- 38 Indicator
- 40 Knowledge management
- 41 Logical framework (Log frame)
- 42 Monitoring
- 25 Policy coherence for sustainable development
- 49 Reliability
- 52 Risk analysis
- 52 Rubric
- 53 Scope of the evaluation
- 56 Terms of reference
- 56 Theory of change
- 57 Transformative effects
- 57 Triangulation
- 57 Validity

### Types of evaluation and analysis

- 24 Cluster evaluation
- 26 Contribution analysis
- 26 Counterfactual
- 27 Country programme evaluation
- 28 Democratic evaluation
- 28 Developmental evaluation
- 29 Economic evaluation
- 30 End line
- 32 Ex-ante evaluation
- 32 Ex-durante evaluation
- 33 Ex-post evaluation
- 33 External evaluation
- 33 Feminist evaluation

- 34 Жендэрийн шинжилгээ
- 38 Шалгуур үзүүлэлт
- 40 Мэдлэгийн менежмент
- 41 Логик хүрээ
- 42 Мониторинг\*
- 25 Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоо
- 49 Найдвартай байдал
- 52 Эрсдэлийн шинжилгээ
- 52 Рубрик
- 53 Үнэлгээний хамрах хүрээ
- 56 Ажлын удирдамж
- 56 Өөрчлөлтийн онол
- 57 Хувьсан өөрчлөлтийн нөлөө
- 57 Гурамсан баталгаажуулалт
- 57 Онч байдал

### Үнэлгээ ба дүн шинжилгээний төрлүүд

- 24 Кластер үнэлгээ
- 26 Хувь нэмрийн дүн шинжилгээ
- 26 Эсрэгцүүлэх баримт
- 27 Улс орны хөтөлбөрийн үнэлгээ
- 28 Ардчилсан үнэлгээ
- 28 Хөгжүүлэлтийн үнэлгээ
- 29 Эдийн засгийн үнэлгээ
- 30 Төгсгөлийн түвшин
- 32 Экс-анте (Урьдчилсан) үнэлгээ
- 32 Явцын үнэлгээ
- 33 Экс-пост (эцсийн) үнэлгээ
- 33 Хөндлөнгийн үнэлгээ
- 33 Феминист үнэлгээ



- 34 Formative evaluation
- 34 Gender-responsive evaluation
- 35 Human rights-based evaluation
- 37 Impact evaluation
- 37 Independent evaluation
- 39 Internal evaluation
- 40 Joint evaluation
- 41 Meta-evaluation
- 41 Mid-term evaluation
- 43 Participatory monitoring and evaluation
- 46 Process evaluation
- 46 Programme evaluation
- 47 Project evaluation
- 48 Randomised Control Trial (RCT)
- 48 Real-time evaluation (real-time learning)
- 51 Review
- 53 Sector programme evaluation
- 53 Self-evaluation
- 54 Social impact evaluation (social impact assessment)
- 54 Summative evaluation
- 56 Thematic evaluation

### Criteria

- 24 Coherence
- 30 Effectiveness
- 30 Efficiency
- 36 Impact
- 49 Relevance
- 55 Sustainability

- 34 Форматив үнэлгээ
- 34 Жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ
- 35 Хүний эрхэд суурилсан үнэлгээ
- 37 Нөлөөллийн үнэлгээ
- 37 Хараат бус үнэлгээ
- 39 Дотоод үнэлгээ
- 40 Хамтарсан үнэлгээ
- 41 Мета үнэлгээ
- 41 Дунд хугацааны үнэлгээ
- 43 Оролцоот мониторинг, үнэлгээ
- 46 Үйл явцын үнэлгээ
- 46 Хөтөлбөрийн үнэлгээ
- 47 Төслийн үнэлгээ
- 48 Санамсаргүйгээр хянах туршилт (RCT)
- 48 Шуурхай(тухайн цаг үеийн) үнэлгээ
- 51 Нягтлал
- 53 Салбарын хөтөлбөрийн үнэлгээ
- 53 Өөрийн үнэлгээ
- 54 Нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ
- 54 Нэгтгэн дүгнэх үнэлгээ
- 56 Сэдэвчилсэн үнэлгээ

### Шалгуур

- 24 Уялдаа холбоо
- 30 Үр дүнтэй байдал
- 30 Үр ашигтай байдал
- 36 Нөлөөлөл
- 49 Нийцтэй байдал
- 55 Тогтвортой байдал

## Results-Based management

- 19 Adaptive management
- 27 Culture of results and learning; Culture of evaluation
- 37 Impact management
- 44 Key Performance Indicator (KPI)
- 42 Monitoring
- 43 Participatory monitoring and evaluation
- 44 Performance
- 44 Performance indicator
- 45 Performance measurement
- 45 Performance measurement framework
- 45 Performance monitoring
- 50 Results
- 50 Results chain
- 50 Results framework
- 51 Results information
- 51 Results-Based Management (RBM)

## Quality and learning

- 25 Conclusions
- 27 Culture of results and learning; Culture of evaluation
- 33 Evaluation feedback
- 32 Evaluation purpose
- 34 Finding
- 44 Key Performance Indicator (KPI)
- 40 Knowledge management
- 40 Lessons learnt
- 41 Limitations
- 44 Performance

## Үр дүнд суурилсан удирдлага

- 19 Дасан зохицох менежмент
- 27 Үр дүн ба сайжруулан суралцах соёл; Үнэлгээний соёл
- 37 Нөлөөллийн удирдлага
- 44 Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт
- 42 Мониторинг\*
- 43 Оролцоот мониторинг, үнэлгээ
- 44 Гүйцэтгэл
- 44 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
- 45 Гүйцэтгэлийн хэмжүүр
- 45 Гүйцэтгэлийг хэмжих хүрээ
- 45 Гүйцэтгэлийн мониторинг
- 50 Үр дүн
- 50 Үр дүнгийн хэлхээ
- 50 Үр дүнгийн хүрээ
- 51 Үр дүнгийн мэдээлэл
- 51 Үр дүнд суурилсан удирдлага (ҮДСУ)

## Чанар ба суралцахуй

- 25 Дүгнэлт
- 27 Үр дүн ба сайжруулан суралцах соёл; Үнэлгээний соёл
- 33 Үнэлгээний эргэх холбоо
- 32 Үнэлгээний зорилго
- 34 Олдвор
- 44 Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт
- 40 Мэдлэгийн менежмент
- 40 Сургамж
- 41 Хязгаарлагдмал байдал
- 44 Гүйцэтгэл



- 44 Performance indicator
- 47 Quality assurance
- 48 Recommendations
- 52 Risk analysis

### Stakeholders

- 23 Beneficiaries (People who benefit)
- 25 Commissioner
- 44 Partner
- 54 Stakeholders
- 55 Target group

### Logical framework

- 19 Activity
- 21 Assumptions
- 22 Baseline (reference value)
- 23 Baseline study
- 23 Benchmark
- 25 Context
- 29 Effects
- 35 Goal
- 35 Hypotheses
- 36 Impact
- 38 Indicator
- 38 Inputs
- 38 Institutional development impact
- 39 Intervention
- 39 Intervention logic
- 40 Intervention purpose

- 44 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
- 47 Чанарын баталгаажуулалт
- 48 Зөвлөмж
- 52 Эрсдэлийн шинжилгээ

### Оролцогч талууд

- 23 Үр өгөөж хүртэгчид (Үр өгөөж хүртэж буй хүмүүс)
- 25 Захиалагч
- 44 Хамтрагч тал
- 54 Оролцогч талууд
- 55 Зорилтот бүлэг

### Логик хүрээ

- 19 Үйл ажиллагаа
- 21 Урьдчилсан таамаглал
- 22 Суурь түвшин (лавлах утга)
- 23 Суурь судалгаа
- 23 Жишиг
- 25 Нөхцөл байдал
- 29 Нөлөө
- 35 Зорилго
- 35 Таамаглал
- 36 Нөлөөлөл
- 38 Шалгуур үзүүлэлт
- 38 Орц
- 38 Институцийн хөгжлийн нөлөөлөл
- 39 Арга хэмжээ
- 39 Арга хэмжээний логик
- 40 Арга хэмжээний зорилго

41	Logical framework (Log frame)
42	Objective (Sustainable development objective)
42	Intervention objective
43	Outcomes
43	Outputs
46	Population
48	Reach
52	Sample
55	Target
56	Theory of change
57	Transformative effects


41	Логик хүрээ
42	Зорилт (Тогтвортой хөгжлийн зорилт)
42	Арга хэмжээний зорилт
43	Үр дагавар
43	Гарц
46	Эх олонлог
48	Хүртэгч/Өртөгч
52	Түүвэр
55	Зорилтот түвшин
56	Өөрчлөлтийн онол
57	Хувьсан өөрчлөлтийн нөлөө





# Terms • Нэр томьёо

The terms are listed in alphabetical order; a table of contents lists the terms by theme.  
Нэр томьёог англи цагаан толгойн дарааллаар оруулсан ба гарчгийг ангиллаар бүлэглэн оруулсан.





## Accountability

Accountability is a state of or a process for holding someone responsible to someone else for something. It is the obligation to demonstrate that work has been conducted in compliance with agreed rules and standards, or to report fairly and accurately on results, based on mandates and plans. This may require a careful, even legally defensible, demonstration that the work is consistent with the terms of a contract.

**Note:** Accountability may refer to the obligations of parties to act according to clearly defined performance expectations, often with respect to the prudent use of resources. For public sector managers and policymakers, it refers to being accountable to stakeholders such as taxpayers, civil society and communities for what has been done, why, and how, including justifying or explaining costs and any negative results. Types of accountability include community accountability, bottom-up accountability, horizontal accountability and top-down accountability.

For evaluators, it connotes the responsibility to provide accurate, fair, and credible reports and assessments.

**Related terms:** community accountability, mutual accountability

---

### (Community) Accountability

Holding intervention funders and implementers accountable to the people and community affected by the intervention for the process and results of that intervention.

## Эгэх хариуцлага

Эгэх хариуцлага гэдэг нь хэн нэгнийг аливаа зүйлийн төлөө хэн нэгний өмнө хариуцлага хүлээлгэх үйл явц эсвэл нөхцөл байдал юм. Энэ нь ажил үүргээ холбогдох дүрэм, стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн гэдгээ харуулах, эсхүл хүлээсэн үүрэг, төлөвлөгөөнд үндэслэн үр дүнг үнэн зөв, шударгаар тайлагнах үүрэг юм. Мөн ажил үүргээ гэрээний нөхцөлд нийцүүлэн гүйцэтгэсэн гэдгийг харуулах нухацтай, тэр ч байтугай хуулиар хамгаалагдах үйл явцыг шаардаж болно.

**Тэмдэглэл:** Эгэх хариуцлага гэдэгт гол төлөв нөөцийг зүй зохистой зарцуулахтай холбоотойгоор талуудын нарийвчлан тодорхойлогдсон гүйцэтгэлийн хүлээлтэд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүргийг ойлгож болно. Энэ нь төрийн байгууллагын удирдлагууд, бодлого боловсруулагчдын хувьд татвар төлөгчид, иргэний нийгэм, нутгийн иргэдийн өмнө юу хийсэн, яагаад, хэрхэн хийснийг тайлагнах, үүний дотор зарцуулалт, аливаа сөрөг үр дагаврын талаар үндэслэл, тайлбар хийх утгыг агуулна. Эгэх хариуцлагын төрөлд иргэдийн өмнө хүлээх, доороос дээш чиглэсэн, хэвтээ болон дээрээс доош чиглэсэн эгэх хххариуцлагууд багтдаг.

Үнэлгээчдийн хувьд эгэх хариуцлага нь үнэн зөв, шударга, үндэслэл бүхий тайлан, үнэлгээг гаргах үүрэг гэсэн утгатай.

**Холбогдох нэр томъёо:** (Иргэдийн өмнө хүлээх) эгэх хариуцлага, хамтын эгэх хариуцлага

---

### Эгэх хариуцлага (иргэдийн өмнө хүлээх)

Тухайн арга хэмжээний үйл явц, үр дүнд нөлөөлөлд өртсөн иргэд, нутгийн иргэдийн өмнө санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч талын хүлээх хариуцлагыг ойлгоно.



### (Mutual) Accountability

Shared responsibility for the intervention implementation and its results. The obligation of two or more partners to demonstrate compliance with mutually agreed rules and standards or to report fairly and accurately on the use of resources and achievement of results for mandated roles or plans. Involves transparent reporting on progress in sustainable development that has been achieved collectively (through contributions from multiple partners) and implications for affected people and other stakeholders.

#### Activity

Actions taken or work performed through which inputs, such as funds, technical assistance and other types of resources, are mobilised to produce specific outputs.

**Synonym:** Intervention

**Related term:** evaluand, intervention

### Adaptive management

A structured management strategy that involves an ongoing process of working collaboratively and flexibly to learn, make decisions, test assumptions, and adjust actions on the basis of new information, lessons and changes in context.

**Note:** Often used to take action under conditions of ongoing uncertainty based on the best available evidence. Involves systematically monitoring and evaluating results and adjusting decisions as more information is learned.

### Эгэх хариуцлага (хамтын)

Тухайн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн төлөөх хамтын хариуцлага. Нөгөө талаас хоёр болон түүнээс дээш хамтрагч талуудын харилцан тохиролцсон дүрэм, стандартад нийцүүлэх, хүлээсэн үүрэг эсвэл төлөвлөгөөнд тусгасан үр дүнгийн биелэлт болон нөөцийн зарцуулалтыг үнэн зөв, шударгаар тайлагнах үүрэг. Энэ нь хамтын хүчээр (талуудын оруулсан хувь нэмэр) бий болгосон тогтвортой хөгжилд гарч буй ахиц дэвшил, нөлөөнд өртөж буй хүмүүс, бусад оролцогч талуудад тусч буй нөлөөллийн талаар ил тод тайлагналыг багтаана.

#### Үйл ажиллагаа

Тухайн үр дүнд хүрэхийн тулд хөрөнгө, техникийн туслалцаа, бусад төрлийн нөөц гэх мэт орцыг ашиглан хийж буй арга хэмжээ, ажил.

**Ижил утгатай үг:** Арга хэмжээ

**Холбогдох нэр томъёо:** Үнэлгээний объект, арга хэмжээ

### Дасан зохицох менежмент

Хамтран ажиллах, засан сайжруулах, шийдвэр гаргах, урьдчилсан таамаглалыг туршихад уян хатан хандах, шинэ мэдээлэл, сургамж, нөхцөл байдлын өөрчлөлтөд үндэслэн үйл ажиллагаанд тохиргоо хийх үргэлжилсэн үйл явцыг оролцуулсан тогтсон удирдлагын стратеги юм. стратеги юм.

**Тэмдэглэл:** Тодорхойгүй нөхцөл байдалд хамгийн боломжит нотолгоонд үндэслэн хариу арга хэмжээ авахад ихэвчлэн хэрэглэдэг. Илүү мэдээлэлтэй болохын хэрээр шийдвэрийг өөрчлөх, үр дүнд системтэйгээр мониторинг, үнэлгээ хийх үйл явц.



## Additionality

The characteristic of an intervention, where its (financial or non-financial) inputs, activities or results are considered as additional when compared to what would have happened otherwise. Additional means larger in scale, at a higher quality, taking place more quickly, at a different location, reaching different beneficiaries, or taking place at all.

**Note:** In development co-operation many institutions distinguish between financial additionality (in reference to financing provided that would not be supplied by the market), and development additionality (referring to results).

---

## Administrative data

Information collected by an intervention for purposes of administration, record keeping and tracking implementation, which can also be used for monitoring and evaluation.

**Note:** Administrative data typically include financial and operational data at activity level. It is common for basic demographic information to be derived from administrative data. Examples include enrolment records, tax records, insurance claims, feedback forms, and patient records.

---

## Analytical tool

Method used to process and interpret data collected or collated.

## Нэмэгдэл

Төлөвлөсөнтэй харьцуулахад нэмэлтээр бий болсон (санхүүгийн болон санхүүгийн бус) орц, үйл ажиллагаа, үр дүн бүхий арга хэмжээний шинж чанар. Нэмэгдэл гэдэг нь илүү өргөн хүрээг хамарсан, илүү өндөр чанартай, илүү түргэн, өөр байршилд хэрэгжсэн, үр өгөөжийг өөр хүмүүст хүрэх, эсвэл бүгдэд хүргэх юм.

**Тэмдэглэл:** Нэмэгдэл гэдгийг хөгжлийн хамтын ажиллагаанд байгууллагууд санхүүгийн нэмэгдэл (зах зээлээс нийлүүлэх боломжгүй санхүүжилтын хувьд) болон хөгжлийн нэмэгдэл (үр дүнгийн хувьд) гэж ялгаж авч үздэг.

---

## Захиргааны өгөгдөл

Тухайн арга хэмжээний хүрээнд захиргааны зорилгоор, тоо, мэдээлэл хадгалах, хэрэгжилтийг нягтлахаар цуглуулсан мэдээллийг хэлнэ. Үүнийг мөн мониторинг, үнэлгээ хийхэд ашиглаж болдог.

**Тэмдэглэл:** Захиргааны өгөгдөлд санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэл багтана. Хүн амзүйн суурь мэдээллийг захиргааны өгөгдлөөс гарган авах нь нийтлэг байдаг. Жишээ нь: ирцийн бүртгэл, татварын мэдээлэл, даатгалын нэхэмжлэл, санал хүсэлтийн маягт болон өвчтөний түүх гэх мэт.

---

## Шинжилгээний арга хэрэгсэл

Цуглуулсан өгөгдлийг тайлбарлах, боловсруулахад хэрэглэх аргачлал.



## Appraisal

An overall assessment of the relevance, feasibility and potential sustainability of an intervention prior to a decision regarding funding or implementation.

**Note:** In development agencies, banks, and other financial institutions, the purpose of the appraisal is to enable decision makers to decide whether the activity represents an appropriate use of resources.

**Related term:** ex-ante evaluation

## Assumptions

A set of (untested) factors and beliefs that form the basis of the intervention logic, and factors or risks, which affect its relevance, progress or success. Assumptions are the conditions necessary for the cause and effect relationships between the different levels of results (i.e. to move from activities to outputs, outputs to outcomes, and outcomes to impacts).

**Note:** For design, monitoring and evaluation, assumptions can also be understood as hypothesised conditions that affect the validity of the exercise itself, e.g., about the size or characteristics of the population when designing a sampling procedure for a survey.

**Related term:** hypotheses, theory of change

## Урьдчилсан үнэлгээ

Санхүүжүүлэх эсхүл хэрэгжүүлэх шийдвэр гаргахын өмнө тухайн арга хэмжээний нийцтэй, хэрэгжихүйц болон боломжит тогтвортой байдлын талаарх ерөнхий үнэлгээ.

**Тэмдэглэл:** Урьдчилсан үнэлгээ нь хөгжлийн байгууллагууд, банк болон бусад санхүүгийн байгууллагуудын шийдвэр гаргагч нарт тухайн үйл ажиллагаа нь нөөцийг зүй зохистой ашиглах эсэх талаар шийдвэр гаргах боломж олгодог.

**Холбогдох нэр томьёо:** ex-ante (урьдчилсан) үнэлгээ

## Урьдчилсан таамаглал

Тухайн арга хэмжээний нийцтэй байдал, ахиц дэвшил эсвэл амжилтад нөлөөлж буй (шалгагдаагүй) хүчин зүйлс, итгэл үнэмшлийн цогц юм. Энэ нь арга хэмжээний логик, хүчин зүйлс, эрсдэлийн суурийг бүрдүүлдэг. Урьдчилсан таамаглал нь өөр өөр түвшний үр дүнгүүдийн хоорондын шалтгаан үр дагаврын харилцан хамаарлыг тодорхойлох нөхцөл юм. (жишээ нь: үйл ажиллагаанаас гарц, гарцаас үр дагавар, үр дагавраас нөлөөлөл рүү шилжихэд)

**Тэмдэглэл:** Төлөвлөлт, мониторинг, үнэлгээний хувьд урьдчилсан таамаглалыг тухайн судалгааны хүчинтэй байдалд нөлөөлөх таамаглал дэвшүүлсэн нөхцөл гэж ойлгож болно. Тухайлбал, судалгааны түүвэр хийх аргачлалыг боловсруулахдаа тухайн судлагдахууны хэмжээ, шинж чанарын талаар таамаглал хийх.

**Холбогдох нэр томьёо:** таамаглал, өөрчлөлтийн онол

## Attribution

The ascription of a causal link between observed (or expected to be observed) changes and a specific intervention.

**Note:** Attribution refers to that which is to be credited for the observed changes or results achieved. This definition does not require that changes are produced solely by the intervention being evaluated, rather it represents the extent to which observed effects can be attributed to a specific intervention or to one or more partners, taking account of other interventions, confounding factors (other influences), or external shocks.

---

## Audit

An independent, systematic, objective quality assurance assessment designed to document and improve the effectiveness of risk management, control and governance processes.

**Note:** A distinction is made between regularity (financial) auditing, which focuses on compliance with applicable statutes and regulations; and performance auditing, which is concerned with relevance, efficiency and effectiveness. Internal auditing provides an assessment of internal controls undertaken by a unit reporting to management while external auditing is conducted by an independent entity.

---

## Baseline (reference value)

The conditions existing prior to an intervention or at the beginning of the period, against which changes can be measured, monitored and evaluated.

## Атрибют

Гарсан өөрчлөлт (эсвэл гарч болох) болон тухайн арга хэмжээ хоорондын учир шалтгааныг тогтоосон байдал.

**Тэмдэглэл:** Гарсан өөрчлөлт эсвэл хүрсэн үр дүнтэй хамаарал бүхий нөхцөл үүссэн бол атрибют гэж хэлж болно. Энэхүү тодорхойлолт нь зөвхөн үнэлгээ хийгдэж буй тухайн арга хэмжээний үр дүнд өөрчлөлт гарсан байх нөхцөлийг шаардахгүй, харин ажиглагдсан нөлөө нь тухайн арга хэмжээ эсвэл нэг буюу түүнээс дээш хамтрагч талуудаас хэр зэрэг хамааралтай байдлыг тогтоохын зэрэгцээ бусад арга хэмжээ, дам хүчин зүйлс (бусад нөлөө) эсхүл гадны цочролыг харгалзан үздэг.

---

## Аудит

Эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр дүнтэй байдлыг сайжруулах, баримтжуулах зорилгоор хийгдэж буй хараат бус, системтэй, чанарын баталгаажуулалтын бодитой үнэлгээ.

**Тэмдэглэл:** Холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэхэд чиглэсэн нийцлийн (санхүүгийн) аудит ба үр ашигтай, үр дүнтэй, нийцтэй байдлыг харгалзан үздэг гүйцэтгэлийн аудит гэж хуваадаг. Дотоод аудит нь аль нэг нэгж дотоод хяналтын үнэлгээг хийж удирдлагад тайлагнадаг бол гадаад аудитыг хөндлөнгийн этгээд хийдэг.

---

## Суурь түвшин (лавлах утга)

Өөрчлөлтийг хэмжих, мониторинг хийх, үнэлэх зорилгоор тогтоосон, арга хэмжээг эхлэхийн өмнөх болон хугацааны эхэн үеийн нөхцөл.



## Baseline study

An analysis describing the situation prior to an intervention, against which changes can be assessed or comparisons made.

## Benchmark

A reference point or standard against which changes, performance or achievements can be assessed.

**Note:** A benchmark is established based on recent performance of comparable organisations, or what can be reasonably inferred to have been achieved under a similar set of circumstances.

## Beneficiaries (People who benefit)

The individuals, groups, or organisations, whether targeted or not, that benefit, directly or indirectly, from the intervention.

**Note:** Other terms used, depending on the context, include rights holders, duty bearers, or affected people.

It is often useful to refer to “intended” beneficiaries, and one should not assume that all people have equal access to or benefit equally (or at all) from the intervention. In fact evaluations often serve the purpose of investigating the extent to which intended benefits were achieved, for whom and how (including differential benefits across different groups of people).

**Related terms:** reach, target group

## Суурь судалгаа

Өөрчлөлтийг үнэлэх, эсхүл харьцуулалт хийх зорилгоор арга хэмжээ эхлэхээс өмнөх нөхцөл байдлыг тодорхойлсон шинжилгээ.

## Жишиг

Өөрчлөлт, гүйцэтгэл, эсхүл амжилтыг үнэлэхэд харьцуулалт хийх эх сурвалж, эсхүл стандарт.

**Тэмдэглэл:** Жишгийг харьцуулж болох байгууллагуудын сүүлийн үеийн гүйцэтгэл эсвэл төстэй нөхцөл байдалд ямар үр дүнд хүрч болох вэ гэдэгт үндэслэн тогтоодог.

## Үр өгөөж хүртэгчид (Үр өгөөж хүртэж буй хүмүүс)

Зорилтот бүлэг байсан эсэхээс үл хамааран тухайн арга хэмжээнээс шууд эсвэл шууд бусаар үр өгөөж хүртсэн хувь хүн, бүлэг, байгууллага.

**Тэмдэглэл:** Нөхцөл байдлаас хамааран эрх эдлэгч тал, үүрэг хүлээгч тал, эсвэл нөлөөлөлд өртсөн хүн гэх мэт өөр нэр томьёо хэрэглэдэг.

“Зорилтот” үр өгөөж хүртэгчдийг авч үзэх нь ач холбогдолтой бөгөөд тухайн арга хэмжээнээс хүн бүр тэгш үр өгөөж хүртэнэ гэж үзэж болохгүй. Үнэн хэрэгтээ үнэлгээ нь зорилтот үр өгөөжийг хэнд, хэрхэн (үүний дотор төрөл бүрийн бүлгүүдэд үр өгөөжийг ялгаатайгаар хүргэсэн байдал) хүргэсэн байдлыг судлах зорилготой байдаг.

**Холбогдох нэр томьёо:** хүртэгч, зорилтот бүлэг



## Causality

The relationship between one event (the cause) and another event (the effect) which is the direct consequence of the first.

## Cluster evaluation

An evaluation of a set of related activities or interventions, either similar interventions in different locations or a cluster of complementary components of an overall initiative.

**Related terms:** thematic evaluation, sector programme evaluation

## Coherence

The compatibility of the intervention with other interventions in a country, sector or institution.

**Note:** The extent to which other interventions (particularly policies) support or undermine the intervention, and vice versa. Includes internal coherence and external coherence:

### *Internal coherence*

The synergies and interlinkages between the intervention and other interventions carried out by the same institution/government, as well as the consistency of the intervention with the relevant international norms and standards to which that institution/government adheres.

### *External coherence*

The consistency of the intervention with other actors' interventions in the same context. This includes complementarity, harmonisation and co-ordination with others, and the extent to which the intervention is adding value while avoiding duplication of effort.

**Related term:** policy coherence for sustainable development

## Шалтгаан үр нөлөө

Тухайн нэг үйл явдал (шалтгаан) болон эхний үйл явдлын шууд үр дагавар болох өөр үйл явдлын (нөлөө) хоорондын хамаарал.

## Кластер үнэлгээ

Өөр хоорондоо уялдаатай үйл ажиллагаа эсхүл арга хэмжээний багц буюу өөр өөр байршил дахь ижил төстэй арга хэмжээ, эсхүл үндсэн санаачилгыг дэмжсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн кластер үнэлгээ.

**Холбогдох нэр томъёо:** сэдэвчилсэн үнэлгээ, салбарын хөтөлбөрийн үнэлгээ.

## Уялдаа холбоо

Тухайн арга хэмжээ нь үндэсний, салбарын эсвэл байгууллагын түвшинд явагдаж буй бусад арга хэмжээтэй уялдсан байдал.

**Тэмдэглэл:** Өөр бусад арга хэмжээ (ялангуяа бодлогууд) нь тухайн арга хэмжээг дэмжиж эсхүл сөргөөр нөлөөлж буй байдлыг, эсрэгээрээ тухайн арга хэмжээ бусад арга хэмжээнд нөлөөлж буй байдал юм. Үүнд дотоод ба гадаад уялдаа холбоо багтана.

### *Дотоод уялдаа холбоо*

Нэг байгууллага, эсхүл засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь цогц, харилцан уялдаатай байхын зэрэгцээ тухайн байгууллага, засгийн газрын мөрдлөг болгодог олон улсын холбогдох хэм хэмжээ, стандарттай нийцсэн байдал.

### *Гадаад уялдаа холбоо*

Тухайн арга хэмжээний бусад байгууллагуудаас ижил нөхцөлд хэрэгжүүлж буй арга хэмжээтэй уялдсан байдал. Үүнд харилцан бие биеэ нөхөх, зохицолдоог хангах, зохицуулах, хүчин чармайлтын давхардлаас зайлсхийхийн зэрэгцээ тухайн арга хэмжээнд оруулж буй үнэ цэн зэрэг багтана.

**Холбогдох нэр томъёо:** тогтвортой хөгжлийн төлөө бодлогын уялдаа холбоо





## Commissioner

The person or entity responsible for requesting or ordering an evaluation.

---

## Policy coherence for sustainable development

The compatibility of a policy with other policies in a country, sector or institution in terms of supporting sustainable development. The extent to which other policies support or undermine the intervention, and vice versa.

Related term: coherence

---

## Conclusions

A summary of the factors leading to the success or failure of the evaluated intervention. Special attention is paid to the intended and unintended effects, results and impacts, and more generally to any other strength or weakness. A conclusion draws on data collection and analyses undertaken, through a transparent chain of arguments.

---

## Context

The setting in which an intervention or an evaluation takes place and which is likely to influence performance and results. These include capacities and social, economic, political, environmental, conflict, inclusiveness, cultural, and institutional conditions.

## Захиалагч

Үнэлгээ хийлгэхээр хүсэлт, захиалга гаргаж буй хүн эсвэл байгууллага.

---

## Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоо

Тухайн бодлого нь тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс үндэсний, салбарын эсвэл байгууллагын бусад бодлоготой нийцэж буй байдал. Бусад бодлого нь тухайн арга хэмжээг дэмжиж буй эсвэл сөрөг нөлөөтэй байдал, эсрэгээр тухайн арга хэмжээний бусад бодлогод нөлөөлж буй байдал.

Холбогдох нэр томъёо: уялдаа холбоо

---

## Дүгнэлт

Үнэлгээ хийгдсэн арга хэмжээний амжилт, эсвэл бүтэлгүйтэлд нөлөөлсөн хүчин зүйлсийн тойм. Урьдчилан тооцоолсон болон тооцоолоогүй нөлөө, үр дүн, нөлөөллийг онцгойлон авч үзэхийн зэрэгцээ бусад давуу ба сул талуудыг ерөнхийд нь нь авч үздэг. Цуглуулсан мэдээлэл, хийсэн дүн шинжилгээ, ил тод, дэс дараатай аргументад үндэслэн дүгнэлт гаргадаг.

---

## Нөхцөл байдал

Тухайн арга хэмжээ, эсвэл үнэлгээ хийгдэж байгаа, гүйцэтгэл болон үр дүнд нөлөөлж болох орчин. Эдгээрт чадавх, нийгэм, эдийн засаг, улс төр, хүрээлэн буй орчин, зөрчил, хүртээмжтэй байдал, соёл, институтийн нөхцөл байдал орно.



## Contribution

The role or part played by an intervention, together with other interventions, in bringing about an observed (or expected) result. The way(s) an intervention helps to advance towards a goal.

---

## Contribution analysis

An approach for determining if – and how – an intervention contributed to an observed result, based on verifying the underlying theory of change.

---

## Control group

The sample or group that does not receive the intervention and against which other groups or samples (that do receive the intervention) are compared in order to assess performance and results.

---

## Counterfactual

The situation or condition that hypothetically may prevail for individuals, organisations, or groups were there no intervention (the status quo).

**Note:** This is used for counterfactual evaluation approaches. It can be estimated by creating a control group, a comparison group or a hypothetical counterfactual.

## Хувь нэмэр

Төлөвлөсөн үр дүнд (хүлээгдэж буй) хүрэхэд чиглэсэн арга хэмжээний хүрээнд болон бусад арга хэмжээний хамт гүйцэтгэсэн ажил үүрэг. Арга хэмжээ зохион байгуулах замаар зорилгодоо хүрэхэд төхөм болдог.

---

## Хувь нэмрийн дүн шинжилгээ

Өөрчлөлтийн онолоор дэвшүүлсэн төсөөллийг магадалсны үндсэн дээр тухайн арга хэмжээ гарсан үр дүнд нөлөөлсөн эсэх, хэрхэн нөлөөлснийг тодорхойлох аргачлал.

---

## Хяналтын бүлэг

Гүйцэтгэл, үр дүнг үнэлэхийн тулд бусад бүлэг, түүвэртэй (арга хэмжээг хүлээн авсан) харьцуулах арга хэмжээг хүлээн аваагүй түүвэр, эсвэл бүлэг.

---

## Эсрэгцүүлэх баримт

Хувь хүмүүс, байгууллага, эсвэл бүлгүүдийн хувьд арга хэмжээ хэрэгжээгүйгээр байж болох хэмээн таамаглал болгон тодорхойлсон нөхцөл байдал (статус кво).

**Тэмдэглэл:** Үүнийг эсрэгцүүлэх баримтын үнэлгээний аргад ашиглагддаг. Тэрээр хяналтын бүлэг, харьцуулах бүлэг эсвэл таамаглал болгосон эсрэгцүүлэх баримт бий болгох замаар тооцоолдог.



## Country programme evaluation

Evaluation of one or more institution's or partner's portfolio of interventions in a specific country, including the strategy behind them in a specific period of time.

---

## Culture of results and learning; Culture of evaluation

The collective formal and informal norms, beliefs and ways of working in an institution that support and encourage staff and partners to actively seek out, learn from and act on credible results information. A culture that supports and encourages people to critically think about the design, implementation and effects of interventions, including relevance, coherence, efficiency, effectiveness, impact and sustainability. This includes understanding causal relationships, testing assumptions and considering evidence generated internally or by external actors on what works or not, why and for whom, and adjusting actions accordingly.

---

## Data collection tool

Methods used to identify information sources and collect information. Examples include informal and formal surveys, direct and participatory observations, community interviews, focus groups, expert opinions, case studies, and literature search.

## Улс орны хөтөлбөрийн үнэлгээ

Тухайн орны нэг ба түүнээс дээш байгууллага эсвэл хамтрагч талуудын арга хэмжээний багц, үүний дотор эдгээр арга хэмжээг зангидаж буй тодорхой хугацаанд хэрэгжүүлж буй стратегийн үнэлгээ.

---

## Үр дүн ба сайжруулан суралцах соёл; Үнэлгээний соёл

Үр дүнгээс суралцах, үр дүнгийн талаарх мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулах арга замыг идэвхтэй эрэлхийлэх талаар ажилтнууд, хамтрагчдаа хөхиүлэн дэмжих байгууллага дахь хамтын албан ба албан бус хэм хэмжээ, итгэл үнэмшил, ажлын арга барил. Арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүний нөлөө, үүний дотор нийцтэй байдал, уялдаа, үр ашиг, нөлөөлөл, тогтвортой байдлын талаар хүмүүс шүүмжтэй хандах явдлыг дэмждэг, урамшуулдаг соёл. Үүнд шалтгаан учир холбогдлыг ойлгох, урьдчилсан таамаглалыг шалгах, юу болж байгаа юу болохгүй байгаа, яагаад, хэнд гэдэг талаар дотоодын болон гадны талуудын бий болгосон нотолгоог авч үзэн зохих тохиргоо хийх багтана.

---

## Өгөгдөл цуглуулах хэрэгсэл

Мэдээллийн эх сурвалжийг тогтоох, мэдээлэл цуглуулахад хэрэглэдэг арга. Жишээнд албан ба албан бус санал асуулга, шууд болон оролцоо бүхий ажиглалт, нутгийн иргэдийн болон фокус бүлгийн ярилцлага, шинжээчийн санал, кэйс судалгаа болон бичиг баримтын судалгаа багтана.



## Democratic evaluation

An approach to evaluation that aims to support a just and democratic society and serve the whole community.

**Note:** Democratic evaluation allows people to be informed of what others are doing and sees the evaluator as someone who brokers the process. It generally uses inclusive practices that foster participation and collaboration to understand progress towards a just and democratic society. Also used as a means of ensuring public accountability and transparency.

## Developmental evaluation

An iterative, embedded approach to evaluation, designed to support learning particularly in complex or uncertain environments. It involves providing real-time, or near real-time, (independent) feedback to intervention staff, thus facilitating ongoing learning and enabling improvements during implementation.

**Related terms:** real-time evaluation, adaptive management, ex-ante evaluation

## Economic

The conversion of inputs (funds, expertise, natural resources, time, etc.) into outputs, outcomes and impacts in the most cost-effective way possible, as compared to feasible alternatives in the context.

**Related term:** efficiency

## Ардчилсан үнэлгээ

Шударга, ардчилсан нийгмийг дэмжих, нутгийн иргэдэд бүхэлд нь үйлчлэхэд чиглэсэн үнэлгээний аргачлал.

**Тэмдэглэл:** Ардчилсан үнэлгээ нь хүмүүст бусдын юу хийж байгаа талаар мэдээлэл авах боломжийг олгохын зэрэгцээ үнэлгээ хийж буй этгээдийг энэхүү үйл явцын зуучлагч гэж үздэг. Энэ нь шударга, ардчилсан нийгмийг бий болгоход гарч буй ахиц дэвшлийг ойлгохын тулд оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжсэн тэгш оролцооны практикийг ашигладаг. Түүнчлэн захиргааны байгууллагуудын эгэх хариуцлага, ил тод байдлыг хангах хэрэгсэл болгон ашигладаг

## Хөгжүүлэлтийн үнэлгээ

Ялангуяа төвөгтэй эсвэл тодорхой бус орчинд суралцах үйл явцыг дэмжихэд чиглэсэн, давтамж бүхий, хатуу тогтоосон үнэлгээний аргачлал. Энэ нь арга хэмжээг хэрэгжүүлэх явцад ажилтнуудтай шууд эргэх холбоотой байснаар тэдэнд тасралтгүй суралцах, чадвараа сайжруулах боломж олгодог.

**Холбогдох нэр томьёо:** хэрэгжилтийн явц дахь үнэлгээ, дасан зохицох менежмент, экс-анте (урьдчилсан) үнэлгээ

## Хэмнэлт

Тухайн нөхцөл байдалд бусад боломжит хувилбаруудтай харьцуулахад орцыг (хөрөнгө, мэргэжлийн туршлага, байгалийн нөөц, цаг хугацаа гэх мэт) хамгийн зардал багатайгаар гарц, үр дагавар, нөлөөлөл болгон хувиргах.

**Холбогдох нэр томьёо:** үр ашигтай байдал



## Economical

Absence of waste for a given output. An activity is economical when the costs of the scarce resources used approximate the minimum needed to achieve the planned objectives.

**Related term:** efficiency

---

## Economic evaluation

An analysis that quantifies whether the economic benefits of a project (achieved or expected to be achieved) exceed its economic costs. A systematic analysis that assesses the resources used in relation to the results achieved, providing an assessment of cost effectiveness.

**Note:** Different types of economic analysis include cost-benefit, value for money, cost-effectiveness and cost-utility.

**Related term:** efficiency

---

## Effects

Intended or unintended changes due directly or indirectly to an intervention.

**Related terms:** outputs, outcomes, impacts, results

## Хэмнэлттэй байх

Гарцыг аливаа алдагдалгүйгээр бий болгох. Үйл ажиллагааг хомсдолтой нөөцийн өртөг нь төлөвлөж буй зорилгод хүрэхэд шаардагдах хамгийн бага түвшинд байхад хэмнэлттэй гэж үзнэ.

**Холбогдох нэр томьёо:** үр ашигтай байдал

---

## Эдийн засгийн үнэлгээ

Төслийн эдийн засгийн өгөөж (хүрсэн эсвэл хүлээгдэж буй) эдийн засгийн зардлаас давсан эсэхийг тоон үзүүлэлтээр илэрхийлэх шинжилгээ. Үр дүнд хүрэхэд ашигласан нөөцийг үнэлж, зардал хэмнэсэн байдлыг тооцох системтэй дүн шинжилгээ.

**Тэмдэглэл:** Эдийн засгийн шинжилгээний төрлүүдэд өртөг-үр өгөөж, мөнгөний үнэ цэнэ, зардал хэмнэсэн байдал, тоон бус үр өгөөжийн үнэлгээ орно.

**Холбогдох нэр томьёо:** үр ашигтай байдал

---

## Нөлөө

Тухайн арга хэмжээний улмаас шууд ба шууд бус гарч буй төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй өөрчлөлтүүд.

**Холбогдох нэр томьёо:** гарц, үр дагавар, нөлөөлөл, үр дүн



## Effectiveness

The extent to which the intervention achieved, or is expected to achieve, its objectives, and its results, including any differential results across groups.

**Note:** Analysis of effectiveness involves taking account of the relative importance of the objectives or results.

**Related terms:** efficiency, coherence, relevance, impact, sustainability

---

## Efficiency

The extent to which the intervention delivers, or is likely to deliver, results in an economic and timely way.

**Note:** “Economic” is the conversion of inputs (funds, expertise, natural resources, time, etc.) into outputs, outcomes and impacts in the most cost-effective way possible, as compared to feasible alternatives in the context. “Timely” delivery is within the intended timeframe, or a timeframe reasonably adjusted to the demands of the evolving context. This may include assessing operational efficiency (how well the intervention was managed).

**Related terms:** effectiveness, coherence, relevance, impact, sustainability

---

## End line

The conditions existing after an intervention or end of the period, against which changes from the baseline can be measured, monitored and evaluated.

**Related term:** baseline

## Үр дүнтэй байдал

Тухайн арга хэмжээ төлөвлөсөн зорилго, хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн байдал, үүний дотор төрөл бүрийн бүлгүүдийн хувьд гарсан ялгаатай үр дүн.

**Тэмдэглэл:** Үр дүнтэй байдлын шинжилгээ нь зорилго эсвэл үр дүнгийн харьцангуй ач холбогдлыг харгалзан үздэг.

**Холбогдох нэр томьёо:** үр ашигтай байдал, уялдаа холбоо, нийцтэй байдал, нөлөөлөл, тогтвортой байдал

---

## Үр ашигтай байдал

Тухайн арга хэмжээ үр дүнг хэмнэлттэй, цаг хугацаанд нь бий болгосон байдал

**Тайлбар:** “Хэмнэлттэй” гэдэг нь орцыг (хөрөнгө, мэргэжлийн туршлага, байгалийн нөөц, цаг хугацаа зэрэг) тухайн нөхцөл байдалд боломжит хувилбаруудтай харьцуулахад хамгийн бага зардлаар гарц, үр дагавар, нөлөөлөл болгон хувиргахыг хэлнэ. “Цаг хугацаанд нь” гэдэг нь төлөвлөсөн хугацаанд эсвэл үүссэн нөхцөл байдлыг харгалзан тогтоосон цаг хугацаанд хийж гүйцэтгэхийг хэлнэ. Үүнд ажиллагааны үр ашиг (арга хэмжээг хэр сайн удирдсан)-ийг үнэлэх багтаж болно.

**Холбогдох нэр томьёо:** үр дүнтэй байдал, уялдаа холбоо, нийцтэй байдал, нөлөөлөл, тогтвортой байдал

---

## Төгсгөлийн түвшин

Суурь түвшинтэй харьцуулан өөрчлөлтийг хэмжих, дүн шинжилгээ, үнэлгээ хийж болох арга хэмжээг хэрэгжүүлсний дараах эсвэл төгсгөлийн үеийн нөхцөл.

**Холбогдох нэр томьёо:** суурь түвшин

## Evaluability

Extent to which an intervention can be evaluated in a reliable and credible fashion.

**Note:** Some approaches to evaluability assessment involve early review of a proposed intervention in order to ascertain whether its objectives are adequately defined and its results are verifiable. In other instances, particularly with complex interventions, high uncertainty or in unstable contexts, evaluability assessment might instead identify a need for an evaluation approach that supports adaptive management (for example, developmental evaluation).

## Evaluand

The institution or intervention that is being evaluated; the object of the evaluation.

## Evaluation

The systematic and objective assessment of a planned, ongoing or completed intervention, its design, implementation and results. The aim is to determine relevance, coherence, effectiveness, efficiency, impact and sustainability. Evaluation also refers to the process of determining the worth or significance of an intervention.

An evaluation should provide information that is credible and useful, enabling the incorporation of lessons learned into decision-making processes.

**Note:** Evaluation in some instances involves the definition of appropriate standards and criteria, the examination of performance against those standards, an assessment of actual and expected results and the identification of relevant lessons and recommendations. Though evaluation deals with the assessment of relevance, coherence, effectiveness, efficiency, impact and sustainability, not all evaluations will cover all of these criteria to the same degree or at all.

## Үнэлэгдэх боломж

Арга хэмжээг найдвартай, хүлээн зөвшөөрөгдөхүйц үнэлэх боломж

**Тэмдэглэл:** Үнэлэгдэх боломжийн үнэлгээнд зорилгыг хангалттай тодорхойлсон, үр дүнг нотлох боломжтой эсэхийг магадлахын тулд санал болгож буй арга хэмжээг эхний шатанд авч үзэх зарим аргачлал байдаг. Бусад тохиолдолд, ялангуяа арга хэмжээ төвөгтэй, тодорхойгүй байдал өндөр эсвэл тогтвортой бус нөхцөлд үнэлэгдэх боломжийн үнэлгээ нь дасан зохицох менежментийг (жишээлбэл, хөгжүүлэлтийн үнэлгээ) дэмжсэн үнэлгээний аргачлалыг шаардаж болно.

## Үнэлгээний объект

Үнэлгээ хийгдэж буй байгууллага эсвэл арга хэмжээ; үнэлгээний объект

## Үнэлгээ

Төлөвлөсөн, хэрэгжиж буй, дуусгавар болсон арга хэмжээ, түүний дизайн, хэрэгжилт, үр дүнгийн талаарх системтэй, бодит үнэлгээ юм. Үнэлгээний зорилго нь нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүнтэй байдал, болон үр ашигтай байдал, нөлөөлөл тогтвортой байдлыг тодорхойлоход оршино. Арга хэмжээ нь үнэ цэнтэй эсэх эсвэл түүний ач холбогдлыг тодорхойлох үйл явцыг мөн үнэлгээ гэж нэрлэдэг.

Үнэлгээ нь найдвартай болон, хэрэглэгдэхүйц мэдээлэл өгөхийн зэрэгцээ олж авсан сургамжийг шийдвэр гаргах үйл явцад тусгах боломжийг олгодог.

**Тайлбар:** Зарим тохиолдолд үнэлгээ нь зохих стандарт, шалгуурыг тодорхойлох, эдгээр стандартын дагуу гүйцэтгэлийг авч үзэх, бодит болон хүлээгдэж буй үр дүнг үнэлэх, холбогдох сургамжийг тодорхойлоход чиглэдэг. Үнэлгээ нь нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүнтэй байдал болон үр ашигтай байдал, нөлөө, тогтвортой байдлыг үнэлэхэд чиглэдэг ч үнэлгээ бүр эдгээр шалгуурыг тэнцүү хэмжээнд авч үзэх шаардлагагүй.



## Evaluation purpose

The objectives of the evaluation including why the evaluation is being undertaken at this particular point in time, for whom and how the evaluation will be used for learning and accountability.

---

## Evidence

Facts or information that support the validity and truth of a conclusion, assumption or assertion.

---

## Evidence-based (policy, practice)

Reliable and credible evidence determines the design, adaptation and implementation of a policy or practice.

---

## Ex-ante evaluation

An evaluation that is performed before the implementation of an intervention.

**Related terms:** appraisal, quality at entry, evaluability

---

## Ex-durante evaluation

An evaluation that is performed during the implementation of an intervention (while it is ongoing).

## Үнэлгээний зорилго

Үнэлгээний зорилго, үүний дотор тухайн үнэлгээг яагаад тухайн цаг хугацаанд хийж байгаа, хэнд зориулж, хэрхэн хийх нь суралцах болон тайлагнах үйл явцтай холбоотой байдаг.

---

## Нотолгоо

Дүгнэлт, урьдчилсан таамаглал эсвэл нотолгооны хүчин төгөлдөр, үнэн зөв байдлыг дэмжсэн баримт эсвэл мэдээлэл.

---

## Нотолгоонд суурилсан (бодлого, практик)

Найдвартай, хүлээн зөвшөөрөгдөхүйц нотолгоо нь аливаа бодлого, практикийн дизайн, тухайн нөхцөлд байдалд тохируулан хийх өөрчлөлт, хэрэгжилтийг тодорхойлдог.

---

## Экс-анте (Урьдчилсан) үнэлгээ

Арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхийн өмнө хийдэг үнэлгээ.

**Холбогдох нэр томьёо:** урьдчилсан үнэлгээ, батлагдахын өмнөх үеийн чанар, үнэлэгдэх боломж

---

## Явцын үнэлгээ

Арга хэмжээг хэрэгжүүлэх үед (явцад нь) хийгддэг үнэлгээ.





## Ex-post evaluation

Evaluation of an intervention after it has been completed.

**Note:** An ex-post evaluation may be undertaken directly following or some time after the intervention. The intention is to identify the factors of success or failure, to assess the sustainability of results and impacts, and to draw conclusions that may inform other interventions.

## External evaluation

The evaluation of an intervention conducted by entities or individuals outside the funding and implementing organisations.

**Related term:** independent evaluation

## Evaluation feedback

The transmission of findings generated through the evaluation process to parties for whom it is relevant and useful so as to facilitate learning or accountability. This may involve the collection and dissemination of findings, conclusions, recommendations and lessons from experience to people affected by the intervention, as well as funders, implementers, decision makers and other stakeholders.

## Feminist evaluation

A value-based approach to evaluation grounded in feminist theory and principles, which emphasises empowerment, social justice and participation, as well as understanding structural barriers that prevent equality, while aiming to contribute to transforming gendered power relationships.

**Related terms:** gender analysis, gender-responsive evaluation, human rights-based evaluation, participatory monitoring and evaluation

## Экс-пост (эцсийн) үнэлгээ

Арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараах үнэлгээ.

**Тэмдэглэл:** Хэрэгжилтийн дараах үнэлгээг арга хэмжээ дуусмагц шууд эсвэл тодорхой хугацааны дараа хийж болно. Тухайн арга хэмжээний ололт амжилт эсвэл бүтэлгүйтлийг тодорхойлох, үр дүн, нөлөөллийн тогтвортой байдлыг үнэлэх, бусад арга хэмжээнд сургаж болох дүгнэлт гаргах зорилготой.

## Хөндлөнгийн үнэлгээ

Арга хэмжээг хэрэгжүүлэгч эсвэл санхүүжүүлэгч байгууллагаас гаднах байгууллага эсвэл хувь хүмүүсээр хийлгэх үнэлгээ.

**Холбогдох нэр томьёо:** Хараат бус үнэлгээ

## Үнэлгээний эргэх холбоо

Суралцах эсвэл эгэх хариуцлагын үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор үнэлгээний үйл явцаас бий болсон баримт нотолгоог холбогдох талуудад хүргэх. Үүнд баримт нотолгоо, дүгнэлт, зөвлөмж, туршлагаас бий болсон сургамжийг цуглуулж, арга хэмжээний нөлөөнд өртсөн хүмүүсийн зэрэгцээ санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч, шийдвэр гаргагчид, бусад оролцогч талуудад түүгээх үйл явц багтана.

## Феминист үнэлгээ

Феминист онол, зарчимд тулгуурласан үнэ цэнд суурилсан үнэлгээний аргачлал бөгөөд хүчирхэгжүүлэх, нийгмийн шударга ёс, оролцоо, тэгш байдлыг хангахад тогтолцооны саад тогторыг ойлгохыг чухалчилснаар жендэрийн эрх мэдлийн харилцааг өөрчлөхөд хувь нэмэр оруулахыг зорьдог.

**Холбогдох нэр томьёо:** Жендэрийн шинжилгээ, жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ, хүний эрхэд суурилсан үнэлгээ, оролцоот мониторинг, үнэлгээ



## Finding

A finding uses evidence from one or more evaluations to allow for a factual statement.

---

## Formative evaluation

Evaluation intended to improve performance or to inform planning of a subsequent phase, often conducted during the implementation phase of the intervention.

**Note:** Formative evaluations may also be conducted for other reasons such as compliance, legal requirements or as part of a larger evaluation initiative.

**Related terms:** process evaluation, developmental evaluation

---

## Gender analysis

An examination of gender dynamics, norms, beliefs and practices, including concepts of masculinity, femininity, and other gender identities, and power relationships among people of different genders.

**Note:** For planning, monitoring and evaluation, gender analysis can be used to understand the intervention and its context, as well as for analysing the results of the intervention and for making evaluative judgements.

---

## Gender-responsive evaluation

An evaluation that assesses changes to gendered power relationships and results from an intervention, determining whether, and how, changes have occurred, and the effects of those changes. The approach to the evaluation ensures that the voices of people of different genders are incorporated throughout the process and in the methods used.

## Олдвор

Олдвор нь үнэн бодит байдлыг илэрхийлэх зорилгоор нэг эсвэл хэд хэдэн үнэлгээний нотолгоог ашигладаг.

---

## Форматив үнэлгээ

Ихэвчлэн арга хэмжээг хэрэгжүүлэх үе шатанд гүйцэтгэлийг сайжруулах эсвэл дараагийн үе шатыг төлөвлөх мэдээлэл цуглуулах зорилгоор хийгддэг үнэлгээ.

**Тэмдэглэл:** Форматив үнэлгээг нийцэл, хуулийн шаардлагаар эсвэл илүү өргөн хүрээний үнэлгээний нэг хэсэг байдлаар хийж болно.

**Холбогдох нэр томъёо:** үйл явцын үнэлгээ, хөгжүүлэлтийн үнэлгээ

---

## Жендэрийн шинжилгээ

Жендэрийн динамик, хэм хэмжээ, итгэл үнэмшил, дадал зуршил, үүний дотор эрэгтэй, эмэгтэй хүний шинжийн тухай ойлголт болон хүйсийн бусад чиг баримжаа, өөр өөр хүйсийн хүмүүсийн эрх мэдлийн харилцааг авч үзэх.

**Тэмдэглэл:** Төлөвлөлт, мониторинг, үнэлгээний хувьд жендэрийн шинжилгээг арга хэмжээ, түүний нөхцөл байдлыг ойлгохын зэрэгцээ арга хэмжээний үр дүнг шинжлэх, үнэлгээний зөвлөмж, дүгнэлт гаргахад ашигладаг.

---

## Жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ

Арга хэмжээний үр дүнд жендэрийн эрх мэдлийн харилцаанд гарсан өөрчлөлт, үр дүн гарсан эсэх, хэрхэн гарсан, эдгээр өөрчлөлтийн нөлөөг тодорхойлдог үнэлгээ. Үнэлгээ нь төрөл бүрийн хүйсийн хүмүүсийн дуу хоолойг үйл явцын турш сонсох, ашиглаж буй аргачлалд тусгах нөхцөлийг хангадаг.



## Goal

The higher-order objective to which an intervention is intended to contribute.

**Note:** An example is the 2030 Sustainable Development Goals (SDGs).

**Related term:** objective

---

## Human rights-based evaluation

An evaluation approach that explicitly identifies rights-holders and duty-bearers, and aims to hold dutybearers to account for the realisation of human rights.

The evaluation applies human rights principles to its approach, including through participation of rights-holders in the evaluation process itself, and explores issues of justice, equity and equality with a focus on marginalised and excluded groups.

---

## Hypotheses

A set of (testable) ideas, beliefs and explanations about the relationship between an intervention and its effects, in a given context.

**Related terms:** assumptions, theory of change, intervention logic

---

## Зорилго

Арга хэмжээ хувь нэмрээ оруулахаар зорьж буй өндөр түвшний зорилго

**Тэмдэглэл:** Жишээ нь Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030

**Холбогдох нэр томьёо:** зорилт.

---

## Хүний эрхэд суурилсан үнэлгээ

Эрх эдлэгч, үүрэг хүлээгчдийг нарийн тодорхойлох үнэлгээний арга бөгөөд үүрэг хүлээгчдийг хүний эрхийг хангахын төлөө хариуцлага хүлээлгэх зорилготой. Үнэлгээ нь эрх эдлэгчдийг үнэлгээний үйл явцад оролцуулах, шударга ёс, тэнцвэртэй байдал, эрх тэгш байдлын асуудлыг гадуурхагдсан, орхигдсон бүлгүүдийн хувьд онцгойлон анхаарч авч үзэх зэргээр хүний эрхийн зарчмуудыг аргачлалдаа хэрэглэдэг.

---

## Таамаглал

Тухайн нөхцөл байдалд арга хэмжээ ба түүний нөлөө хоорондын хамаарлын талаарх санаа (турших боломжтой), итгэл үнэмшил, тайлбар.

**Холбогдох нэр томьёо:** урьдчилсан таамаглал, өөрчлөлтийн онол, арга хэмжээний логик

---



## Impact

The extent to which the intervention has generated or is expected to generate significant positive or negative, intended or unintended, higher-level effects.

**Note:** Impact addresses the ultimate significance and potentially transformative effects of the intervention. It seeks to identify social, environmental and economic effects of the intervention that are longer term or broader in scope than those already captured under the effectiveness criterion. Beyond the immediate results, impact seeks to capture the indirect, secondary and potential consequences of the intervention. It does so by examining the holistic and enduring changes in systems or norms, and potential effects on people's well-being, human rights, gender equality, and the environment.

**Related terms:** relevance, coherence, effectiveness, efficiency, sustainability

## Impacts

The higher-level effects of an intervention's outcomes. The ultimate effects or longer-term changes resulting from the intervention. Such impacts can include intended and unintended, positive or negative higher-level effects.

**Note:** Impacts is used here in the plural in reference to its meaning as a type or level of result, as distinct from the impact criterion. "Impacts" and "results" are sometimes used interchangeably, which creates confusion; impacts should be used to refer to higher-level results.

**Related term:** transformative effects

## Нөлөөлөл

Тухайн арга хэмжээний төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй, өндөр түвшний, эерэг эсвэл сөрөг нөлөө бий болгосон эсвэл хүлээгдэж буй байдал

**Тэмдэглэл:** Нөлөөлөлд тухайн арга хэмжээний туйлын ач холбогдол, суурь шинжтэй өөрчлөлт бий болгох нөлөөг авч үздэг. Энэ нь арга хэмжээний урт хугацааны, үр дүнтэй байдлын шалгуурт авч үзсэнээс өргөн хүрээний нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засгийн нөлөөг тодорхойлохыг зорьдог. Нөлөөлөлд тухайн арга хэмжээний шууд үр дүнгээс цааш шууд бус, хоёрдогч, боломжит үр дагавруудыг авч үздэг. Чингэхдээ тогтолцоо эсвэл хэм хэмжээнд гарсан цогц, тогтвортой өөрчлөлт болон иргэдийн аж байдал, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, хүрээлэн буй орчинд үзүүлж болох нөлөөг авч үздэг.

**Холбогдох нэр томъёо:** нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, тогтвортой байдал

## Нөлөөллүүд

Арга хэмжээний үр дүнгийн дээд түвшний нөлөө. Тухайн арга хэмжээнээс үүдэлтэй эцсийн нөлөө эсвэл урт хугацааны өөрчлөлт юм. Ийм нөлөөлөлд төлөвлөсөн болон төлөвлөөгүй өндөр түвшний эерэг эсвэл сөрөг нөлөө багтана.

**Тэмдэглэл:** Энд нөлөөг нөлөөллийн шалгуураас ялгахын тулд олон тоон дээр хэрэглэсэн нь үр дүнгийн төрөл эсвэл түвшнийг илэрхийлэхийг зорьсон болно. "Нөлөөлөл", "үр дүн"-г заримдаа сольж хэрэглэдэг нь төөрөгдөл үүсгэдэг бөгөөд нөлөөллийг дээд түвшний үр дүнг илэрхийлэхэд хэрэглэдэг.

**Холбоотой нэр томъёо:** хувьсан өөрчлөлтийн нөлөө



## Impact evaluation

An evaluation that assesses the degree to which the intervention meets its higher-level goals and identifies the causal effects of the intervention. Impact evaluations may use experimental, quasi-experimental and non-experimental approaches.

**Note:** The term is also sometimes used to refer only to evaluations that use explicit counterfactual analysis to determine the effects (including outputs and outcomes) caused by an intervention.

## Impact management

A management strategy focusing on performance and achievement of impacts. This management approach provides the framework, tools and guidance for strategic planning, risk management, performance monitoring, evaluation and knowledge management. It serves four complementary purposes: decisionmaking, learning, accountability and communication.

**Synonym:** results-based management

## Independent evaluation

An evaluation that is free from undue political influence and organisational pressure, which has full access to information and autonomy to carry out investigations and reports findings and conclusions based on the collected evidence.

**Note:** Independence is often supported by having external individuals or institutions carry out the evaluation. Independence can also be supported through funding arrangements, reporting lines and quality assurance processes. The credibility of an evaluation depends in part on how independently it has been carried out, including the extent to which it is free from the potential biases of those responsible for the design and implementation of the intervention.

## Нөлөөллийн үнэлгээ

Арга хэмжээний дээд түвшний зорилгод хүрсэн байдлыг үнэлж, учир холбогдлын нөлөөг тодорхойлдог үнэлгээ. Нөлөөллийн үнэлгээнд туршилтын, хагас туршилтын, туршилтын бус аргуудыг ашиглаж болно.

**Тэмдэглэл:** Энэ нэр томъёо зарим тохиолдолд арга хэмжээнээс үүдэлтэй нөлөөг (гарц, үр дагаврыг оролцуулан) тодорхойлоход чиглэсэн эсрэг баримтын дүн шинжилгээг ашигласан үнэлгээнд хэрэглэдэг.

## Нөлөөллийн удирдлага

Нөлөөллийн гүйцэтгэл, ололтод чиглэсэн менежментийн стратеги. Менежментийн энэ арга барил нь стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, гүйцэтгэлийн мониторинг, үнэлгээ, мэдлэгийн менежментэд хүрээ, арга хэрэгсэл, удирдамж болдог. Энэ нь шийдвэр гаргах, суралцах, эгэх хариуцлага, харилцаа холбоо гэсэн дөрвөн бие биеэ дэмжсэн зорилготой.

**Ойролцоо утга:** үр дүнд суурилсан удирдлага

## Хараат бус үнэлгээ

Улс төрийн нөлөө, байгууллагын дарамтаас ангид, мэдээлэл авах, шалгалт хийх бүрэн эрхтэй, цуглуулсан нотолгоонд үндэслэн баримт нотолгоо, дүгнэлтийг тайлагнах үнэлгээ.

**Тэмдэглэл:** Хараат бус байдал нь үнэлгээг гаднын хүмүүс эсвэл байгууллага хийснээр хангагддаг. Түүнчлэн санхүүжилтийн зохицуулалт, тайлагнах шатлал, чанарын баталгаажуулалтын үйл явцаар дамжуулан хараат бус байдлыг хангаж болно. Үнэлгээний хүлээн зөвшөөрөгдөх байдал нь хараат бус байдлыг хэрхэн хангасан, үүний дотор төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцсан этгээдүүдийн нөлөөнөөс ангид байдлыг хэр хангаснаас хамаарна.



## Indicator

Quantitative or qualitative factor or variable of interest, related to the intervention and its results, or to the context in which an intervention takes place.

**Note:** An indicator is always approximate only (i.e. not an exact measure) and requires interpretation and explanation, even if assessed accurately. Indicators should provide simple, verifiable, and reliable means to track changes and performance.

**Related terms:** KPI, performance indicator

---

## Inputs

The financial, human, material (in-kind), and institutional (including technological and information) resources used for the intervention.

**Note:** It is important to include not only the resources of a funding or implementing organisation but the totality of resources of all involved organisations, the community and the local environment used for the intervention.

---

## Institutional development impact

The extent to which an intervention improves or weakens the ability of a country or region to make more efficient, equitable, and sustainable use of its human, financial, and natural resources, for example through: (a) better definition, stability, transparency, enforceability and predictability of institutional arrangements, or (b) better alignment of the mission and capacity of an organisation with its mandate, which derives from these institutional arrangements. Such impacts can include intended and unintended effects of an action.

## Шалгуур үзүүлэлт

Арга хэмжээ, түүний үр дүн, эсвэл тухайн арга хэмжээ хэрэгжсэн нөхцөл байдалтай холбоотой тоон болон чанарын хүчин зүйлс эсвэл хувьсах тоон хэмжигдэхүүн.

**Тэмдэглэл:** Шалгуур үзүүлэлт нь үргэлж ойролцоо дүнгээр (өөрөөр хэлбэл, яг нарийн утга биш) илэрхийлэгдэх бөгөөд үнэн зөв тооцоолсон ч тайлбар, тайлал шаардлагатай байдаг. Өөрчлөлт, гүйцэтгэлийг мөшгөхөд энгийн, нягтлах боломжтой, найдвартай шалгуур үзүүлэлт шаардлагатай байдаг.

**Холбогдох нэр томъёо:** Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

---

## Орц

Арга хэмжээнд ашигласан санхүүгийн, хүний, материалын (мөнгөн бус) болон институцийн (технологийн болон мэдээллийн гэх мэт) нөөц.

**Тэмдэглэл:** Санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагын нөөц төдийгүй оролцсон бүх байгууллага, нутгийн иргэд, орон нутгийн хүрээлэн буй орчны арга хэмжээнд ашигласан нөөцийг оруулах нь чухал.

---

## Институцийн хөгжлийн нөлөөлөл

Арга хэмжээ тухайн орны эсвэл бүс нутгийн, хүний, санхүүгийн, байгалийн нөөцийг илүү үр ашигтай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ашиглах чадварт сайжруулсан эсвэл буруулсан байдал. Жишээлбэл: (а) институцийн зохион байгуулалтыг илүү сайн тодорхойлох, түүний тогтвортой, ил тод, урьдаас тодорхой байдлыг хангах, дагаж мөрдүүлэх, эсвэл (б) институцийн эдгээр зохион байгуулалттай холбоотойгоор тухайн байгууллагын эрхэм зорилго, чадавхыг чиг үүрэгтэй нь сайтар уялдуулах замаар. Ийм нөлөөлөлд үйл ажиллагааны төлөвлөсөн болон төлөвлөсөн нөлөөг оруулж болно



## Internal evaluation

Evaluation of an intervention conducted by a unit or individuals internal to the organisation, generally staff of the organisation who report to the management.

**Related term:** self-evaluation

## Intervention

The intentional activity or effort that is being evaluated (also called the evaluand or object of the monitoring or evaluation).

**Note:** Interventions may be international, national, local or through partnerships, and are aimed at supporting sustainable development, climate and humanitarian goals. They include but are not limited to development interventions, humanitarian aid, peacebuilding activities, climate mitigation activities, climate adaptation activities, market-based interventions, private sector engagement, normative work, and non-sovereign operations. Examples of such efforts include strategies, policy advice, technical assistance, financing mechanisms, programmes, institutions, or projects.

**Synonym:** evaluand

**Related term:** activity

## Intervention logic

The way an intervention is expected to achieve its desired results, including underlying assumptions about the causality and interaction between the intervention, its inputs, activities, outputs, outcomes and impacts, in the context of the intervention.

**Related terms:** logical framework, theory of change, assumptions

## Дотоод үнэлгээ

Байгууллагын дотоод нэгж эсвэл хувь хүмүүс, ерөнхийдөө удирдлагадаа тайлагнадаг ажилтнуудын хийсэн арга хэмжээний үнэлгээ.

**Холбогдох нэр томьёо:** өөрийн үнэлгээ

## Арга хэмжээ

Үнэлгээ хийгдэж байгаа төлөвлөсөн үйл ажиллагаа эсвэл хүчин чармайлт (үүнийг мөн үнэлгээний объект эсвэл мониторинг, үнэлгээний объект гэж нэрлэдэг).

**Тэмдэглэл:** Арга хэмжээ нь олон улсын, үндэсний, орон нутгийн эсвэл хамтын ажиллагааны хүрээнд байж болох бөгөөд тогтвортой хөгжил, уур амьсгал, хүмүүнлэгийн зорилтуудыг дэмжихэд чиглэдэг. Эдгээрт хөгжлийн арга хэмжээ, хүмүүнлэгийн тусламж, энхийг сахиулах үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг бууруулах үйл ажиллагаа, зах зээлд үндэслэсэн үйл ажиллагаа, хувийн хэвшлийн оролцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажил, санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажиллагаа багтах ч эдгээрээр хязгаарлагдахгүй. Эдгээр арга хэмжээний жишээнд стратеги, бодлогын зөвлөгөө, техникийн туслалцаа, санхүүжилтийн механизм, хөтөлбөр, байгууллагууд, төслүүдийг дурдаж болно.

**Ойролцоо утга:** Үнэлгээний объект

**Холбогдох нэр томьёо:** үйл ажиллагаа

## Арга хэмжээний логик

Тухайн нөхцөл байдалд арга хэмжээ хүсэж байгаа үр дүндээ хүрэх арга зам, үүний дотор учир холбогдлын болон арга хэмжээ ба түүний орц, үйл ажиллагаа, гарц, үр дагавар, нөлөөллийн хамаарлын талаарх төсөөлөл.

**Холбогдох нэр томьёо:** логик хүрээ, өөрчлөлтийн онол, урьдчилсан таамаглал



## Intervention purpose

The stated (or implied) objectives of the intervention.

**Related terms:** intervention objective, goal

---

## Joint evaluation

An evaluation in which two or more institutions or partners participate.

**Note:** There are various degrees of “jointness” depending on the extent to which individual partners are involved in designing the evaluation, co-operate in the evaluation process, merge their evaluation resources and combine their evaluation reporting. Joint evaluations can help overcome attribution problems in assessing the effectiveness of programmes and strategies. They can also be useful for evaluating coherence, looking at the complementarity of efforts supported by different partners, the quality of co-ordination, etc.

---

## Knowledge management

The process or approach through which institutions capture, distribute, retain and effectively use knowledge to achieve their goals.

---

## Lessons learnt

Generalisation or extrapolation of findings and translation of analysis into relevant knowledge that supports decision making, improves performance and promotes the achievement of better results in other settings (beyond the intervention being evaluated).

Frequently, lessons highlight strengths or weaknesses in the preparation, design, and implementation of interventions that affect performance and results. A lesson may be positive, neutral or negative.

## Арга хэмжээний зорилго

Арга хэмжээний дэвшүүлэн тавьсан зорилтууд.

**Холбогдох нэр томъёо:** арга хэмжээний зорилт, зорилго

---

## Хамтарсан үнэлгээ

Хоёр ба түүнээс дээш байгууллага эсвэл хамтрагч талууд оролцсон үнэлгээ.

**Тэмдэглэл:** Үнэлгээг төлөвлөх, үнэлгээний үйл явцад хамтран ажиллаж байгаа байдлаас хамааран “хамтрах” түвшин өөр өөр байдаг бөгөөд үнэлгээ хийх зардлыг хамтарч гаргах, эсвэл үнэлгээний тайланг нэгтгэн гаргаж болно. Хамтарсан үнэлгээ нь хөтөлбөр, стратегийн үр дүнтэй байдлыг үнэлэхэд тулгардаг хамаатуулах нөлөөний асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Түүнчлэн төрөл бүрийн хамтрагч талуудын дэмжиж буй үйл ажиллагаануудын бие биеэ дэмжсэн байдал, зохицуулалтын чанар зэрэг уялдаа холбоог авч үзэхэд хэрэгтэй байж болно.

---

## Мэдлэгийн менежмент

Байгууллага зорилгодоо хүрэхийн тулд мэдлэгийг олж авах, түгээх, хадгалах, үр дүнтэй ашиглах үйл явц эсвэл арга зам.

---

## Сургамж

Баримт нотолгоо, дүн шинжилгээнээс ерөнхийлөл, дүгнэлт хийж, шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах, бусад нөхцөл байдалд (үнэлгээ хийгдэж буй арга хэмжээнээс цааш) илүү үр дүнд хүрэхэд чиглэсэн, холбогдох мэдлэг болгон хувиргах.

Сургамж нь гүйцэтгэл, үр дүнд нөлөөлөх арга хэмжээний бэлтгэлийг хангах, төлөвлөх, хэрэгжүүлэхэд гарсан давуу эсвэл сул талуудад анхаарал хандуулдаг. Сургамж нь эерэг, төвийг сахисан эсвэл сөрөг байж болно.





## Limitations

Any constraints in the process, methodology or data that affect the monitoring or evaluation, including potential implications for validity and reliability. Includes any obstruction of a free and open monitoring and evaluation process that may influence the findings, as well as discrepancies between the planned and actual products or process.

---

## Logical framework (Log frame)

Management tool used to improve the design of interventions, most often at the project level. It involves identifying strategic elements (inputs, activities, outputs, outcomes, impacts) and their causal relationships, as well as indicators, and the assumptions or risks that may influence success and failure. It facilitates planning, execution, monitoring and evaluation of an intervention.

**Related terms:** results-based management, theory of change, intervention logic

---

## Meta-evaluation

The assessment of an evaluation (or a body of evaluations) to judge its quality or scrutinise the performance of the evaluators

---

## Mid-term evaluation

Evaluation performed towards the middle of the period of implementation of the intervention.

**Related terms:** formative evaluation, developmental evaluation.

## Хязгаарлагдмал байдал

Мониторинг, үнэлгээ, үүний дотор түүний үнэн зөв, найдвартай байдалд нөлөөлөх үйл явц, арга зүй, өгөгдөл дэх аливаа хязгаарлалт. Баримт нотолгоонд нөлөөлж болзошгүй мониторинг, үнэлгээг чөлөөтэй нээлттэй явуулахад учирсан саад бэрхшээл, төлөвлөсөн болон бодит байдал дахь бүтээгдэхүүн эсвэл үйл явцын зөрүү.

---

## Логик хүрээ

Ихэвчлэн төслийн түвшинд арга хэмжээний дизайныг сайжруулахад ашигладаг менежментийн хэрэгсэл. Үүнд стратегийн элементүүд (орц, үйл ажиллагаа, гарц, үр дагавар, нөлөөлөл), тэдгээрийн учир холбогдол, амжилт, бүтэлгүйтэлд нөлөөлж болох төсөөлөл, эрсдэлийг тодорхойлох зэрэг орно. Энэ нь арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг, үнэлгээ хийх үйл явцыг зураглахад тустай байдаг.

**Холбогдох нэр томъёо:** үр дүнд суурилсан удирдлага, өөрчлөлтийн онол, арга хэмжээний логик

---

## Мета үнэлгээ

Үнэлгээний чанарыг тодорхойлох эсвэл үнэлгээ хийж буй этгээдийн гүйцэтгэлд хяналт тавихад ашигладаг үнэлгээг (багц үнэлгээ) ийнхүү нэрлэж болно.

---

## Дунд хугацааны үнэлгээ

Арга хэмжээний хэрэгжилтийн дунд үед хийсэн үнэлгээ.

**Холбогдох нэр томъёо:** хөгжүүлэлтийн үнэлгээ, хөгжлийн үнэлгээ



## Monitoring

A continuing process that involves the systematic collection or collation of data (on specified indicators or other types of information). Provides the management and other stakeholders of an intervention with indications of the extent of implementation progress, achievement of intended results, occurrence of unintended results, use of allocated funds and other important intervention and context-related information.

**Related terms:** performance monitoring, performance indicator, indicator

## Objective (Sustainable development objective)

Intended positive impacts contributing to physical, financial, institutional, social, well-being, environmental, or other benefits to a society, community, or group of people via one or more interventions.

**Related term:** intervention objective

## Intervention objective

The overall purpose of an intervention. This includes the intended physical, financial, institutional, social, environmental, or other results that an intervention is expected to achieve or to which it is expected to contribute.

**Related terms:** intervention purpose, goal

## Мониторинг\*

Өгөгдлийг (тодорхой шалгуур үзүүлэлт эсвэл бусад төрлийн мэдээллийн дагуу) системтэйгээр цуглуулах, нэгтгэх, харьцуулах, шинжлэх тасралтгүй үйл явц. Арга хэмжээний хэрэгжилтийн явц, төлөвлөсөн болон төлөвлөөгүй үр дүнд хүрсэн байдал, хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, бусад чухал арга хэмжээ, нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг удирдлага, бусад оролцогч талуудад өгөх зорилготой.

**Холбогдох нэр томъёо:** гүйцэтгэлийн мониторинг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлт

\* Манай улсад одоо мөрдөгдөж буй хуулиудад хяналт-шинжилгээ, үнэлгээ нэршлүүдийг хамтад нь хэрэглэх нь түгээмэл. Гэвч эдгээр нэршлүүд нь хоорондоо зорилго, давтамж, цар хүрээний хувьд ихээхэн ялгаатай юм. Ялангуяа “хяналт-шинжилгээ” гэдэг нэршлийг мониторинг гэж нэршиж үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд авч үзэж байгаа бөгөөд энэхүү тайлбар тольд мониторинг гэдэг утгаар нь хэрэглэсэн болно.

## Зорилт (Тогтвортой хөгжлийн зорилт)

Нэг ба түүнээс дээш арга хэмжээ хэрэгжүүлснээр нийгэм, олон нийт, бүлэг хүмүүст чиглэсэн биет, санхүүгийн, институцийн, нийгмийн, сайн сайхан байдал, хүрээлэн буй орчин, бусад үр өгөөжд хувь нэмэр оруулах эерэг нөлөө.

**Холбогдох нэр томъёо:** арга хэмжээний зорилт

## Арга хэмжээний зорилт

Арга хэмжээний ерөнхий зорилго. Үүнд арга хэмжээний хүрэхээр зорьж буй эсвэл хувь нэмэр оруулахаар хүлээгдэж буй биет, санхүүгийн, институцийн, нийгмийн, хүрээлэн буй орчны болон бусад үр дүн орно.

**Холбогдох нэр томъёо:** арга хэмжээний зорилго, зорилго



## Outcomes

The short-term and medium-term effects of an intervention's outputs.

**Note:** Outcomes are often changes in the institutional and behavioural capacities for development conditions that occur between the completion of outputs and the achievement of impacts.

**Related terms:** results, outputs, impacts, effect.

---

## Outputs

The products, capital goods and services that result from an intervention. Outputs may also include changes resulting from the intervention that contribute to the achievement of outcomes. Outputs include changes in knowledge, skills, or abilities produced by the activities.

**Note:** Outputs are within the control of the implementing team and attributable to it.

**Related term:** results

---

## Participatory monitoring and evaluation

An evaluation approach in which partners (including target groups) work together and are actively involved in monitoring and evaluation including designing plans, collecting and interpreting data, documenting and using findings, and formulating conclusions and recommendations.

## Үр дагавар

Арга хэмжээний гарцын богино болон дунд хугацааны нөлөө.

**Тэмдэглэл:** Үр дагавар гэж ихэвчлэн гарц дуусгавар болсон болон нөлөөлөл бий болох хооронд хөгжлийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн институцийн болон зан үйлийн чадавхад гарсан өөрчлөлтийг хэлнэ.

**Холбогдох нэр томьёо:** үр дүн, гарц, нөлөөлөл, нөлөө.

---

## Гарц

Арга хэмжээний үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, бараа, үйлчилгээ. Үүнд үр дагаварт хувь нэмэр оруулах арга хэмжээний үр дүнд бий болсон өөрчлөлтүүдийг хамруулж болно. Түүнчлэн үйл ажиллагаанаас бий болсон мэдлэг, ур чадвар, чадавхын өөрчлөлтийг хамруулж болно.

**Тэмдэглэл:** Гарцыг хэрэгжүүлэгч баг хянах боломжтой, нөлөө нь түүнтэй хамаатай байдаг.

**Холбогдох нэр томьёо:** үр дүн

---

## Оролцоот мониторинг, үнэлгээ

Хамтрагч талууд (үүний дотор зорилтот бүлгүүд) хамтарч ажиллан, мониторинг, үнэлгээ, үүний дотор төлөвлөгөө боловсруулах, өгөгдөл цуглуулах, тайлбарлах, баримт нотолгоог баримтжуулах, ашиглах, дүгнэлт, зөвлөмж боловсруулахад идэвхтэй оролцдог үнэлгээний арга.



## Partner

An individual or organisation that collaborates on an intervention to achieve mutually agreed objectives.

**Note:** The concept of partnership connotes shared goals, common responsibility for outcomes, distinct accountabilities and reciprocal obligations. Partners may include communities, governments (national regional, local), civil society organisations, non-governmental organisations, universities, professional and business associations, private entities, and multi-lateral organisations involved in funding, implementing or overseeing the intervention.

## Performance

The degree to which an intervention or partner operates according to specific criteria, standards and guidelines, or achieves results in accordance with stated goals or plans.

## Performance indicator

Quantitative or qualitative factor or variable that provides a simple, verifiable, and reliable means to measure the performance of an actor, generally in terms of the process of implementation.

**Related terms:** KPI, indicator

## Key Performance Indicator (KPI)

A subset of indicators that are considered to be the most important to achieving goals, and used to monitor progress, in an ongoing way.

**Related terms:** indicator, performance

## Хамтрагч тал

Харилцан тохиролцсон зорилгод хүрэхийн тулд арга хэмжээн дээр хамтран ажиллаж буй хувь хүн, байгууллага.

**Тэмдэглэл:** Хамтын ажиллагааны үзэл баримтлал нь нэгдмэл зорилго, үр дүнгийн төлөөх нийтлэг хариуцлага, ялгаатай эгэх хариуцлага, харилцан хүлээх үүргийг илэрхийлдэг.

Хамтрагч талууд гэдэгт арга хэмжээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавихад оролцож буй нутгийн иргэд, төв засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, их дээд сургууль, мэргэжлийн болон бизнесийн холбоод, хувийн хэвшлийн байгууллага, үндэстэн дамнасан байгууллагуудыг хамруулж болно.

## Гүйцэтгэл

Арга хэмжээ эсвэл хамтрагч талууд үйл ажиллагаагаа тодорхой шалгуур, стандарт, удирдамжийн дагуу явагдаж байгаа, эсвэл дэвшүүлсэн зорилго, төлөвлөгөөний дагуу үр дүнд хүрсэн байдал.

## Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Аливаа этгээдийн (хувь хүн, байгууллага) хэрэгжилтийн үйл явцын гүйцэтгэлийг хэмжих энгийн, нотлох боломжтой, найдвартай хэрэгслийг бий болгодог тоон эсвэл чанарын хүчин зүйлс эсвэл хувьсагч.

**Холбогдох нэр томъёо:** Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд, шалгуур үзүүлэлт

## Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт

Зорилгод хүрэхэд хамгийн чухалд тооцогдох, ахиц дэвшлийг тасралтгүй хянахад ашигладаг шалгуур үзүүлэлтүүдийн дэд хэсэг.

**Холбогдох нэр томъёо:** шалгуур үзүүлэлт, гүйцэтгэл



## Performance measurement

A system for assessing performance of interventions against stated goals.

**Related terms:** performance monitoring, performance indicator, indicator.

---

## Performance monitoring

A continuous process of collecting and analysing data to compare how well an intervention is being implemented against expected results.

**Related term:** performance measurement

---

## Performance measurement framework

The performance measurement framework is a results-based management tool used to systematically plan the collection of relevant data over the lifetime of the project, in order to assess and demonstrate progress made in achieving expected results. The performance measurement framework is the “skeleton” of the monitoring plan: it documents the major elements of the monitoring system in order to ensure regular collection of actual data on the performance measurement framework indicators. The performance measurement framework contains all of the indicators used to measure progress on the achievement of the project’s results.

In addition, it specifies who is responsible for collecting data on the indicator, from what source, at what frequency and with what method. It also includes the baseline data and target for each indicator.

**Related terms:** Result framework

---

## Гүйцэтгэлийн хэмжүүр

Арга хэмжээний гүйцэтгэлийг дэвшүүлсэн зорилготой харьцуулан үнэлэх СИСТЕМ.

**Холбогдох нэр томьёо:** гүйцэтгэлийн мониторинг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлт.

---

## Гүйцэтгэлийн мониторинг

Хүлээж буй үр дүнтэй харьцангуй арга хэмжээ хэр сайн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх тасралтгүй үйл явц.

**Холбогдох нэр томьёо:** гүйцэтгэлийн хэмжүүр

---

## Гүйцэтгэлийг хэмжих хүрээ

Гүйцэтгэлийг хэмжих хүрээ нь хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд гарсан ахиц дэвшлийг үнэлэх, харуулах зорилгоор төсөл хэрэгжих хугацаанд холбогдох өгөгдлийг цуглуулах ажлыг системтэйгээр төлөвлөхөд ашигладаг үр дүнд суурилсан удирдлагын хэрэгсэл юм. Гүйцэтгэлийг хэмжих хүрээ нь мониторинг төлөвлөгөөний “арга яс” юм. Тэрээр гүйцэтгэлийг хэмжих хүрээний шалгуур үзүүлэлтүүдийн бодит мэдээллийг тогтмол цуглуулах нөхцөлийг хангахын тулд мониторингийн тогтолцооны үндсэн элементүүдийг баримтжуулдаг. Гүйцэтгэлийг хэмжих хүрээ нь төслийн үр дүнд хүрэх ахиц дэвшлийг хэмжихэд ашигладаг бүх шалгуур үзүүлэлтүүдийг агуулдаг.

Үүний зэрэгцээ тухайн шалгуур үзүүлэлтийн мэдээллийг хэн, ямар эх сурвалжаас, ямар давтамжтайгаар, ямар аргаар цуглуулахыг зааж өгдөг. Мөн шалгуур үзүүлэлт тус бүрийн суурь ба зорилтот түвшний мэдээллийг тусгасан байна.

**Холбогдох нэр томьёо:** үр дүнгийн хүрээ

---



## Population

The total universe of persons or institutions in the context in which the intervention takes place; all potential targets of the intervention.

**Note:** The target group of an intervention is a subset of the population

**Related terms:** target group, people who benefit, stakeholders

---

## Process evaluation

An evaluation of the internal dynamics of implementing organisations, their policy instruments, their service delivery mechanisms, their management practices, and the linkages among these.

**Related term:** formative evaluation

---

## Programme evaluation

Evaluation of a set of interventions, combined to attain specific global, regional, country, or sector development objectives.

**Note:** a development programme is a time-bound intervention involving multiple activities that may cut across sectors, themes and geographic areas.

**Related term:** country programme evaluation.

---

## Эх олонлог

Арга хэмжээ хэрэгжиж буй нөхцөл байдалд байгаа нийт хувь хүн эсвэл байгууллагууд; арга хэмжээний бүх боломжит зорилтот хэсгүүд.

**Тэмдэглэл:** Арга хэмжээний зорилтот бүлэг нь эх олонлогийн нэг дэд олонлог юм.

**Холбогдох нэр томьёо:** зорилтот бүлэг, үр өгөөж хүртэгсэд, оролцогч талууд

---

## Үйл явцын үнэлгээ

Хэрэгжүүлэгч байгууллагуудын дотоод динамик, бодлогын арга хэрэгсэл, үйлчилгээ хүргэх механизм, удирдлагын арга барил, тэдгээрийн уялдаа холбоо зэрэгт хийх үнэлгээ.

**Холбогдох нэр томьёо:** Форматив үнэлгээ.

---

## Хөтөлбөрийн үнэлгээ

Дэлхий нийт, бүс нутаг, улс орон, салбарын хөгжлийн тодорхой зорилтуудад хүрэхээр хийгдэж буй багц арга хэмжээний үнэлгээ.

**Тэмдэглэл:** Хөгжлийн хөтөлбөр нь олон салбар, сэдэв, газарзүйн бүс нутгийг хамарсан олон тооны үйл ажиллагааг хамарсан, тодорхой цаг хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ юм.

**Холбогдох нэр томьёо:** Улс орны хөтөлбөрийн үнэлгээ.

---



## Project evaluation

Evaluation of an individual intervention designed to achieve specific objectives within specified resources and implementation schedules, often within the framework of a broader programme, examining its relevance, coherence, effectiveness, efficiency, impact and sustainability.

**Note:** Cost-benefit analysis is one instrument often used in project evaluation for projects with measurable benefits. When benefits cannot be quantified, cost effectiveness is a suitable approach.

## Quality assurance

Any activity or process that is used to assess and improve the merit or the worth of an intervention or its compliance with given standards and requirements.

**Note:** Examples of quality assurance activities include appraisal, results-based management, reviews, and evaluations. Quality assurance may also refer to the assessment of the quality of a portfolio and its overall effectiveness.

## Quality at entry

The strength of the intervention implementation and results, at the time it is designed or before it starts, in terms of its potential relevance, effectiveness, coherence, efficiency, impact and sustainability.

**Note:** Quality at entry may also be a factor of the extent to which the intervention design is evidence informed, including the involvement of stakeholders in the conceptualisation of the intervention.

**Related terms:** evaluability, ex-ante evaluation

## Төслийн үнэлгээ

Ихэвчлэн илүү өргөн хүрээний хөтөлбөрийн хүрээнд тодорхой зорилтуудад чиглэсэн, тодорхой нөөц, хуваарийн дагуу хэрэгжүүлж буй тухайн нэг арга хэмжээг түүний нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүн, үр ашиг, нөлөөлөл, тогтвортой байдлыг авч үзэх үнэлгээ.

**Тэмдэглэл:** Хэмжиж болохуйц үр шимтэй төслүүдийн хувьд өртөг-үр өгөөжийн дүн шинжилгээг төслийн үнэлгээнд ашигладаг. Үр өгөөжийг тоогоор илэрхийлэх боломжгүй тохиолдолд өртөг-үр дүнгийн шинжилгээ тохиромжтой арга зам болно.

## Чанарын баталгаажуулалт

Арга хэмжээний ач холбогдол, үнэ цэнэ эсвэл тогтоосон стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх, сайжруулахад ашигладаг аливаа үйл ажиллагаа, үйл явц.

**Тэмдэглэл:** Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны жишээнд урьдчилсан үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлага, хяналтыг дурдаж болно. Мөн багц (portfolio)-ын чанар, түүний ерөнхий үр дүнгийн үнэлгээг чанарын баталгаажуулалт гэж ойлгож болно.

## Төсөл батлагдахын өмнөх үеийн чанар

Арга хэмжээний төлөвлөсөн үйл ажиллагаа, үр дүнгийн нийцтэй, үр дүнтэй, уялдаа холбоотой, үр ашигтай, нөлөөтэй, тогтвортой байдлын батлагдахаас өмнөх үеийн чанар.

**Тэмдэглэл:** Өөрөөр хэлбэл төсөл батлагдахын өмнөх үеийн чанар гэдэг нь арга хэмжээг боловсруулахдаа оролцогч талуудын оролцоог хангах замаар нотолгоонд суурилсан төлөвлөлтийг хэр түвшинд хийснийг илэрхийлнэ.

**Холбогдох нэр томъёо:** үнэлэгдэх боломж, ex-ante (урьдчилсан) үнэлгээ



## Randomised Control Trial (RCT)

A type of evaluation that randomly assigns access to the intervention, in order to control influencing variables and limit bias, generating internally valid estimates of results.

---

## Reach

The people affected by an intervention, as a subset of the total population.

**Related terms:** people who benefit, target group, population

---

## Real-time evaluation (real-time learning)

A process that provides immediate (independent) evaluative evidence, insights and feedback to inform decision making, learning and implementation while the intervention is underway.

**Related term:** monitoring

---

## Recommendations

Proposals aimed at enhancing the relevance, coherence, effectiveness, efficiency, impact or sustainability of the intervention; at redesigning the objectives; or reallocating resources. Recommendations should be based on findings and conclusions.

## Санамсаргүйгээр хянах туршилт (RCT)

Ерөнхийдөө үр дүнг дотооддоо үнэн зөв тооцоолох, нөлөөлөх хувьсагчуудыг хянах, нэг талыг барьсан нөлөөллийг хязгаарлах зорилгоор тухайн арга хэмжээг санамсаргүйгээр сонгон авах үнэлгээний хэлбэр.

---

## Хүртэгч/Өртөгч

Тухайн арга хэмжээнд өртсөн, нийт эх олонлогийн нэг хэсэг болох хүмүүс.

**Холбогдох нэр томьёо:** үр өгөөж хүртсэн хүмүүс, зорилтот бүлэг, эх олонлог

---

## Шуурхай (тухайн цаг үеийн) үнэлгээ

Арга хэмжээ хийх явцад шийдвэр гаргах, суралцах, хэрэгжүүлэхэд мэдээлэл өгөх зорилгоор шууд (бие даасан) үнэлгээ, ойлголт, санал хүсэлтийг өгдөг үйл явц.

**Холбогдох нэр томьёо:** Мониторинг

---

## Зөвлөмж

Арга хэмжээний нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүн, үр ашиг, нөлөөлөл, тогтвортой байдлыг сайжруулах, зорилтуудыг дахин тодорхойлох, эсвэл нөөцийн хуваарилалтыг өөрчлөхөд чиглэсэн санал. Зөвлөмж нь баримт нотолгоо, дүгнэлтэд үндэслэсэн байх шаардлагатай.





## Relevance

The extent to which the intervention objectives and design respond to beneficiaries, global, country, and partner/institution needs, policies, and priorities, and continue to do so if circumstances change.

**Note:** “Respond to” means that the objectives and design of the intervention are sensitive to the economic, environmental, equity, social, political economy, and capacity conditions in which it takes place. “Partner/institution” includes government (national, regional, local), civil society organisations, private entities and international bodies involved in funding, implementing and/or overseeing the intervention. Relevance assessment involves looking at differences and trade-offs between different priorities or needs. It requires analysing any changes in the context to assess the extent to which the intervention can be (or has been) adapted to remain relevant.

**Related terms:** beneficiares (people who benefit), coherence, effectiveness, efficiency, impact, sustainability.

## Reliability

Consistency or dependability of data and evaluation judgements, with reference to the quality of the instruments, procedures and analyses used to collect and interpret results and evaluation data.

**Note:** Evaluation and results information is reliable when repeated observations using similar instruments under similar conditions produce similar results.

## Нийцтэй байдал

Тухайн арга хэмжээний зорилтууд, дизайн нь үр өгөөж хүртэгчид, олон улсын, үндэсний, хамтрагч байгууллагын хэрэгцээ, бодлого, тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж буй, нөхцөл байдал өөрчлөгдсөн ч хадгалагдах байдал.

**Тэмдэглэл:** "Нийцэх" гэдэг нь арга хэмжээний зорилтууд, загвар нь тухайн арга хэмжээ хэрэгжиж буй эдийн засаг, хүрээлэн буй орчин, тэгш боломж, нийгэм, улс төр, эдийн засаг, чадавхын нөхцөл байдалд мэдрэмжтэй байхыг хэлнэ. "Хамтрагч/байгууллага" гэдэгт арга хэмжээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавихад оролцож буй төв засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн, олон улсын байгууллагууд орно. Нийцтэй байдлын үнэлгээнд өөр өөр тэргүүлэх чиглэл эсвэл хэрэгцээний ялгаатай байдал, харилцан буултыг авч үздэг. Тэрээр нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, арга хэмжээ нийцтэй байдалаа хадгалахын тулд зохих өөрчлөлт оруулахыг шаарддаг.

**Холбогдох нэр томъёо:** үр өгөөж хүртэгчид (үр өгөөж хүртдэг хүмүүс), уялдаа холбоо, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, нөлөөлөл, тогтвортой байдал

## Найдвартай байдал

Үр дүнгийн болон үнэлгээний өгөгдлийг цуглуулах, тайлбарлахад ашигласан арга хэрэгсэл, горим, дүн шинжилгээний чанартай хамааралтайгаар үнэлгээний өгөгдөл, дүгнэлтийн логик уялдаатай, найдвартай байдал.

**Тэмдэглэл:** Адил төстэй нөхцөлд адил төстэй арга хэрэгслийг ашиглан ажиглалтыг давтамжтай хийснээр адил төстэй үр дүн гарсан тохиолдолд үнэлгээ, үр дүнгийн мэдээлэл найдвартай байдаг.

## Results

The outputs, outcomes or impacts (intended or unintended, positive or negative) of an intervention.

**Related terms:** outputs, outcomes, effects, impacts

---

## Results chain

The causal sequence of an intervention that stipulates the different stages leading to the achievement of the desired objectives. In general, the results chain starts with inputs, which then link to activities and outputs, and culminate in outcomes, and impacts. In some cases, reach is included as part of the results chain.

**Related terms:** inputs, activities, outputs, outcomes, impact, results framework, theory of change, performance measurement framework

---

## Results framework

Explicit articulation (typically, in a graphical or tabular manner) of how a strategy or intervention will achieve the objective(s), including causal relationships and underlying assumptions and risks.

**Note:** Generally, includes indicators (with baseline, data source, means of verification, etc. for each) for the full results chain: inputs, activities, outputs, outcomes and impacts. In some instances, results frameworks only describe the desired outputs, outcomes and impacts, leaving flexibility to define the inputs and activities that will lead to these results.

**Related terms:** results chain, logical framework, theory of change, intervention logic.

---

## Үр дүн

Арга хэмжээний гарц, үр дагавар эсвэл нөлөөлөл (төлөвлөсөн болон төлөвлөсөн бус, эерэг эсвэл сөрөг)

**Холбогдох нэр томъёо:** гарц, үр дагавар, нөлөө, нөлөөлөл

---

## Үр дүнгийн хэлхээ

Арга хэмжээ хүсэж буй зорилгодоо хүрэх төрөл бүрийн үе шатуудыг харуулсан учир холбогдлын дэс дараалал. Ерөнхийдөө үр дүнгийн хэлхээ нь орцоос эхэлж, үйл ажиллагаа, гарцыг дамжин, үр дагавар, нөлөөлөлд хүрэх замтай байдаг. Зарим тохиолдолд нөлөөлөлд өртөгсдийг үр дүнгийн хэлхээнд оруулдаг.

**Холбогдох нэр томъёо:** орц, үйл ажиллагаа, гарц, үр дагавар, нөлөөлөл, үр дүнгийн хүрээ, өөрчлөлтийн онол, гүйцэтгэлийг хэмжих хүрээ

---

## Үр дүнгийн хүрээ

Тухайн стратеги эсвэл арга хэмжээ дэвшүүлсэн зорилтдоо хэрхэн хүрэхийг (график эсвэл хүснэгт) учир холбогдлын харилцаа, дэвшүүлсэн таамаглал, эрсдэлийн хамт тодорхойлсон томъёол.

**Тэмдэглэл:** Ерөнхийдөө үр дүнгийн бүрэн хэлхээнд орц, үйл ажиллагаа, гарц, үр дагавар, нөлөөлөл, шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт тус бүрийн суурь түвшин, мэдээллийн эх сурвалж, баталгаажуулах арга хэрэгслийн хамт)-ийг багтаадаг. Зарим тохиолдолд үр дүнгийн хүрээ нь зөвхөн хүсэж буй гарц, үр дагавар, нөлөөллийг тодорхойлж, эдгээр үр дүнд хүрэхэд шаардлагатай орц, үйл ажиллагааг тодорхойлох явдлыг уян хатан үлдээдэг.

**Холбогдох нэр томъёо:** үр дүнгийн хэлхээ, логик хүрээ, өөрчлөлтийн онол, арга хэмжээний логик

---



## Results information

Qualitative or quantitative data about the outputs, outcomes or impacts (intended or unintended, positive or negative) of an intervention.

**Related terms:** indicator; result, performance indicator

## Results-Based Management (RBM)

A management strategy focusing on performance and achievement of outputs, outcomes and impacts. This management approach provides the framework, tools and guidance for strategic planning, risk management, performance monitoring, evaluation and knowledge management. It serves four complementary purposes: decision-making, learning, accountability and communication.

**Note:** RBM is often a participatory and team-based management approach designed to improve programme delivery and strengthen management effectiveness, efficiency, learning and accountability.

## Review

An assessment of the performance of an intervention, periodically or on an ad hoc basis.

**Note:** Sometimes the terms “review” and “evaluation” are used as synonyms. However an evaluation is generally a more systematic and comprehensive assessment than a review. Reviews tend to emphasise operational aspects.

**Related term:** evaluation

## Үр дүнгийн мэдээлэл

Арга хэмжээний гарц, үр дагавар, нөлөөллийн (төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй, эерэг эсвэл сөрөг) чанарын болон тоон мэдээлэл.

**Холбогдох нэр томъёо:** шалгуур үзүүлэлт; үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

## Үр дүнд суурилсан удирдлага (ҮДСУ)

Гүйцэтгэл, гарц, үр дагавар, нөлөөллийг бий болгоход чиглэсэн менежментийн стратеги. Менежментийн энэ арга нь стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, гүйцэтгэлийн мониторинг, үнэлгээ, мэдлэгийн менежментийн хүрээ, арга хэрэгсэл, чиглэл болдог. Тэрээр шийдвэр гаргах, суралцах, эгэх хариуцлага, харилцаа холбоо гэсэн дөрвөн бие биеэ дэмжсэн зорилгод үйлчилдэг.

**Тэмдэглэл:** ҮДСУ нь ихэвчлэн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, удирдлагын үр дүн, үр ашиг, суралцах үйл явц, эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн оролцоо, багийн ажиллагаанд суурилсан удирдлагын арга барил юм.

## Нягтлал

Тодорхой давтамжтай эсвэл тохиолдлын байдлаар хийдэг арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ.

**Тэмдэглэл:** Заримдаа "нягтлах", "үнэлгээ" гэсэн нэр томъёог хооронд нь сольж хэрэглэдэг. Гэхдээ үнэлгээ нь ерөнхийдөө нягтлахаас илүү системтэй, цогц дүн шинжилгээ юм. Нягтлах нь гол төлөв ажиллагаатай холбоотой асуудлуудыг хөнддөг.

**Холбогдох нэр томъёо:** үнэлгээ



## Risk analysis

An analysis or an assessment of factors that affect or are likely to affect the achievement of an intervention's objectives. A detailed examination of the potential unwanted and negative consequences to human life, health, property, or the environment posed by an intervention; a systematic process to provide information regarding such undesirable consequences; the process of quantification of the probabilities and expected impacts for identified risks.

---

## Rubric

A framework that sets out criteria and standards for different levels of performance and describes what performance would look like at each level, as a way of answering evaluative questions. It also includes guidance on how to synthesise evidence to form an overall evaluative conclusion.

---

## Sample

A subset of a given population which is chosen in such a way as to allow extrapolation of findings to the population.

**Note:** Extrapolation can be done statistically for random sampling and analytically for purposeful sampling.

**Related terms:** counter-factual, population

## Эрсдэлийн шинжилгээ

Арга хэмжээ зорилтдоо хүрэхэд нөлөөлж буй эсвэл нөлөөлөх боломжтой хүчин зүйлсийн дүн шинжилгээ, үнэлгээ. Арга хэмжээний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй хүсээгүй, сөрөг үр дагаврыг нарийвчлан судлах; иймэрхүү хүсээгүй үр дагаврын талаар мэдээлэл өгөх системтэй үйл явц; тодорхойлсон эрсдэлүүдийн учрах магадлал, хүлээгдэж буй үр дагаврыг тооцоолох үйл явц.

---

## Рубрик

Гүйцэтгэлийн төрөл бүрийн түвшний шалгуур, стандартууд, түвшин бүрд гүйцэтгэл ямар байхыг үнэлгээний асуултуудад хариулах аргаар тодорхойлох хүрээ. Тэрээр үнэлгээний ерөнхий дүгнэлтийг боловсруулахад шаардлагатай нотлох баримтыг хэрхэн нэгтгэн дүгнэх чиглэл болдог.

---

## Түүвэр

Баримт нотолгоог эх олонлогт хамааруулан дүгнэлт хийхээр сонгон авсан эх олонлогийн нэг дэд олонлог.

**Тэмдэглэл:** Нэгдсэн дүгнэлтийг статистикийн хувьд санамсаргүй түүврийн аргаар, дүн шинжилгээний хувьд зориуд сонгон авсан түүврээр хийж болно.

**Холбогдох нэр томъёо:** эсрэг баримт, эх олонлог



## Scope of the evaluation

The time period, funds, geographical area, target group(s), organisational set-up, implementation arrangements, policy and institutional context, and other dimensions covered by the evaluation.

**Note:** The scope of the evaluation should be delineated along at least four levels: operational (all or part of the areas of intervention, one or more related policies or interventions), institutional (all or part of the authorities), temporal (period taken into account) and geographic (one or more territories or parts of territories, a specific region, city, place, etc.).

## Sector programme evaluation

Evaluation of a cluster of interventions within one country or across countries, all of which contribute to the achievement of a specific goal.

**Note:** a sector includes development activities commonly grouped together for the purpose of public action such as health, education, agriculture, transport, etc.

## Self-evaluation

An evaluation of an intervention by those who are responsible for its design and delivery.

**Related term:** internal evaluation

## Үнэлгээний хамрах хүрээ

Үнэлгээ хийх хугацаа, санхүүжилт, газар зүйн байршил, зорилтот бүлгүүд, зохион байгуулалтын бүтэц, хэрэгжүүлэх механизм, бодлогын болон институцийн нөхцөл байдал, бусад асуудлыг үнэлгээнд хамруулдаг.

**Тэмдэглэл:** Үнэлгээний хамрах хүрээг багадаа дөрвөн түвшинд зааглана. Үүнд: ажиллагааны (арга хэмжээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн, нэг эсвэл түүнээс дээш холбогдох бодлого эсвэл арга хэмжээ), институцийн (байгууллагыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн), цаг хугацааны (хугацааг харгалзан үзэх), газар зүйн байршил (нэг буюу хэд хэдэн нутаг дэвсгэр эсвэл нутаг дэвсгэрийн нэг хэсэг, тодорхой бүс нутаг, хот, газар гэх мэт).

## Салбарын хөтөлбөрийн үнэлгээ

Тодорхой зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулахаар нэг эсвэл хэд хэдэн улсад хэрэгжиж арга хэмжээнүүдийн багцын үнэлгээ.

**Тэмдэглэл:** салбар гэдэгт төрөөс олон нийтэд зориулан хэрэгжүүлж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, тээвэр зэрэг нэгтгэн бүлэглэсэн хөгжлийн үйл ажиллагааг ойлгоно.

## Өөрийн үнэлгээ

Арга хэмжээг төлөвлөсөн, хэрэгжүүлсэн этгээдийн хийсэн үнэлгээ.

**Холбогдох нэр томъёо:** дотоод үнэлгээ



### Social impact evaluation (social impact assessment)

An evaluation that determines (ex-ante or ex-post) the likely or actual social effects of an intervention. Involves the intended and unintended social consequences, both positive and negative, of interventions and any social change processes affected by the intervention.

---

### Stakeholders

Agencies, organisations, groups or individuals who have a direct or indirect interest in the intervention or its monitoring and evaluation.

---

### Strategic evaluation

An evaluation that examines how priorities are formulated, looking at overall systems and trends affecting performance and results.

---

### Summative evaluation

A study conducted at the end of an intervention (or a phase of that intervention) to determine the extent to which anticipated outcomes were produced. Summative evaluation is intended to provide information about the worth or significance of the intervention.

### Нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Арга хэмжээний (өмнө эсвэл дараа) нийгэмд гарч болох эсвэл бодит нөлөөг тогтоох үнэлгээ. Үүнд арга хэмжээний үр дүнд бий болсон төлөвлөсөн болон төлөвлөгөөгүй эерэг, сөрөг нийгмийн үр дагаврууд, нийгмийн өөрчлөлтийн аливаа үйл явцыг хамруулна.

---

### Оролцогч талууд

Арга хэмжээ, түүний мониторинг, үнэлгээнд оролцох шууд болон шууд бус ашиг сонирхолтой байгууллагууд, бүлгүүд, хувь хүмүүс.

---

### Стратегийн үнэлгээ

Тэргүүлэх чиглэлүүдийг хэрхэн тодорхойлж байгаа гүйцэтгэл, үр дүнд нөлөөлж буй ерөнхий тогтолцоо, чиг хандлагыг авч үзэх үнэлгээ.

---

### Нэгтгэн дүгнэх үнэлгээ

Төлөвлөсөн үр дүнд хүрсэн түвшнийг тодорхойлохын тулд арга хэмжээний төгсгөлд (эсвэл арга хэмжээний үе шатанд) хийгддэг судалгаа. Нэгтгэн дүгнэх үнэлгээ нь тухайн арга хэмжээ үнэ цэнтэй байдал, ач холбогдлын талаарх мэдээлэл өгөх зорилготой.



## Sustainability

The extent to which the net benefits of the intervention continue, or are likely to continue.

**Note:** Includes an examination of the financial, economic, social, environmental, and institutional capacities of the systems needed to sustain net benefits over time. Involves analyses of resilience, risks and potential trade-offs. Depending on the timing of the evaluation, this may involve analysing the actual flow of net benefits or estimating the likelihood of net benefits continuing over the medium and long term.

## Target

An objective, usually quantitative, defined as a value on an established indicator. The target is generally set at the beginning of an intervention and is expected to be achieved by a specific point in time with available resources.

**Related term:** performance indicator

## Target group

The specific individuals, communities or organisations that the intervention is intended to reach.

**Note:** Can also be defined as the recipients of the goods and services produced by the intervention, or whose skills or capacities have changed because of the intervention. The target group may or may not be the individuals or organisations that, ultimately, are intended to benefit from the intervention.

**Related term:** reach

## Тогтвортой байдал

Арга хэмжээний цэвэр үр өгөөж тогтвортой хадгалагдах эсвэл хадгалагдах боломжтой байдал.

**Тэмдэглэл:** Цэвэр үр өгөөжийг тогтвортой хадгалахад шаардлагатай санхүү, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, тогтолцооны институцийн чадавхад хийсэн дүн шинжилгээ орно. Тэсвэрлэх чадвар, эрсдэл, боломжит харилцан буултын дүн шинжилгээ багтана. Үнэлгээ хийгдэж буй цаг хугацаанаас хамааран цэвэр үр өгөөжийн бодит урсгалын дүн шинжилгээ эсвэл цэвэр үр өгөөж дунд болон урт хугацаанд хадгалагдах магадлалыг тооцно.

## Зорилтот түвшин

Тогтоосон шалгуур үзүүлэлтийн хувьд зорилго болгон авсан, гол төлөв тоон утгаар илэрхийлсэн утга. Зорилтот түвшнийг арга хэмжээний эхэн үед тодорхойлох бөгөөд байгаа нөөцийн хүрээнд тодорхой хугацаанд хүрэх ёстой тодорхой цэг юм.

**Холбогдох нэр томъёо:** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

## Зорилтот бүлэг

Арга хэмжээг хүргэхээр зорьж буй тодорхой хувь хүмүүс, олон нийт эсвэл байгууллагууд.

**Тэмдэглэл:** Арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болсон бараа, үйлчилгээг хүлээн авагч, эсвэл арга хэмжээний үр дүнд ур чадвар, чадавхад нь өөрчлөлт гарсан хүмүүс гэж тодорхойлж болно. Зорилтот бүлэг нь арга хэмжээнээс үр өгөөж хүртэхээр төлөвлөсөн хувь хүмүүс, байгууллагууд байх албагүй.

**Холбогдох нэр томъёо:** хүртэгч/өртөгч



## Terms of reference

Written document presenting the purpose and scope of the evaluation, the methods to be used, the standard against which performance is to be assessed or analyses are to be conducted, the resources and time allocated, and reporting requirements.

**Note:** Two alternative expressions sometimes used are “scope of work” and “evaluation mandate”.

---

## Thematic evaluation

Evaluation of a selection of interventions, all of which address a specific sustainable development priority or topic, that cuts across countries, regions, and sectors.

**Note:** Often thematic evaluations will examine a strategic approach or priority topic across a variety of interventions. An example would be evaluating the extent to which the rights of people with disabilities were advanced across a portfolio of interventions in education, health and employment.

---

## Theory of change

The way the intervention is expected to achieve or achieves change. It represents how people understand change to occur in a given context, including explicit (or implicit) assumptions about the causal links between inputs, activities and results. Often also includes evidence and risks for these elements of the results chain.

**Related terms:** intervention logic, logical framework, results chain, assumptions

## Ажлын удирдамж

Үнэлгээний зорилго, хамрах хүрээ, ашиглах аргачлал, ажлын гүйцэтгэлийг үнэлэх эсвэл дүн шинжилгээ хийх стандарт, хуваарилагдсан нөөц ба цаг хугацаа, тайлангийн шаардлагуудыг тусгасан баримт бичиг.

**Тэмдэглэл:** “ажлын хүрээ” ба “үнэлгээний удирдамж” гэсэн өөр хоёр хувилбарыг зарим тохиолдолд ашигладаг.

---

## Сэдэвчилсэн үнэлгээ

Улс орнууд, бүс нутгууд, салбаруудыг хамарсан тогтвортой хөгжлийн тодорхой тэргүүлэх чиглэл эсвэл сэдвийг хөндсөн, сонгон авсан арга хэмжээнүүдийн үнэлгээ.

**Тэмдэглэл:** Сэдэвчилсэн үнэлгээ нь ихэвчлэн стратегийн хандлага эсвэл төрөл бүрийн арга хэмжээний тэргүүлэх чиглэлийн сэдвийг хамардаг. Жишээ нь боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн салбарын арга хэмжээнүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрхэн хангасныг үнэлэх юм.

---

## Өөрчлөлтийн онол

Арга хэмжээний өөрчлөлт бий болгохоор хүлээгдэж буй арга зам. Энэ нь тухайн нөхцөл байдал дахь өөрчлөлт, үүний дотор орц, үйл ажиллагаа, үр дүн хоорондын учир холбогдлын талаарх тодорхой (эсвэл далд) урьдчилсан таамаглалыг хүмүүс хэрхэн ойлгож байгааг тусгадаг. Ихэвчлэн үр дүнгийн эдгээр элементийн хувьд нотолгоо, эрсдэлийг мөн агуулсан байдаг.

**Холбогдох нэр томъёо:** арга хэмжээний логик, логик хүрээ, үр дүнгийн хэлээ, урьдчилсан таамаглал





## Transformative effects

Holistic and enduring changes in systems or norms.

**Related term:** impacts

---

## Triangulation

The use of three or more theories, sources or types of information, or types of analysis to verify and substantiate an assessment.

**Note:** Seeks to overcome the bias that comes from single informants, single methods, single observers or single theory studies by combining multiple data sources, methods, analyses or theories, monitoring and evaluation.

---

## Validity

The extent to which an evaluation is logically and factually sound. Also used to describe the quality of data collection strategies and instruments to accurately measure what they purport to measure.

## Хувьсан өөрчлөлтийн нөлөө

Систем эсвэл хэм хэмжээний цогц бөгөөд тогтвортой өөрчлөлтүүд.

**Холбогдох нэр томъёо:** нөлөөлөл

---

## Гурамсан баталгаажуулалт

Үнэлгээг магадлах, баримтаар нотлохын тулд гурав ба түүнээс дээш онол, эх сурвалж, мэдээллийн төрлүүд эсвэл дүн шинжилгээний төрлүүдийг ашиглах.

**Тэмдэглэл:** Мэдээллийн олон эх сурвалж, аргачлал, дүн шинжилгээ, онол, мониторинг, үнэлгээг хослуулах замаар нэг мэдээлэгч, нэг арга, нэг ажиглагч эсвэл нэг онолын судалгааны өрөөсгөл талыг арилгахыг зорьдог.

---

## Онч байдал

Үнэлгээ нь логик, баримт нотолгооны хувьд үндэслэлтэй байдал. Түүнчлэн мэдээлэл цуглуулах стратеги, хэмжих зүйлсийг үнэн зөв хэмжих арга хэрэгслийн чанарыг тодорхойлоход ашигладаг.

# Glossary of Key Terms in Evaluation and Results-Based Management for Sustainable Development

Second edition

This Glossary defines concepts and terms commonly used in evaluation and results-based management. It provides a shared understanding to support the design, management, monitoring and evaluation of interventions for sustainable development. As a reference document, it is helpful for those commissioning, managing, or conducting evaluations, as well as people involved in strategy or programme development, management and implementation. While originally developed for international development co-operation, the Glossary can be applied in any field of public policy and is also useful for civil society, academia, and other non-state actors.

This second edition includes updated content, including new definitions for the widely used evaluation criteria – relevance, coherence, effectiveness, efficiency, impact and sustainability – endorsed by the OECD Development Assistance Committee in 2019. It also provides minor updates to the original text to reflect current good practice. As concepts and language are constantly evolving, the document will be revisited and updated in due course.



2024

ISBN 978-92-64-38930-4

# Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томьёоны тайлбар толь

2 дахь хэвлэл

Энэ нэр томьёоны тайлбар толинд үр дүнд суурилсан удирдлага болон үнэлгээ хийхэд хэрэглэгддэг түгээмэл дэлгэрсэн ойлголт, нэр томьёог тайлбарласан болно. Тус тайлбар толь нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн арга хэмжээний загвар, удирдлага, мониторинг, үнэлгээг сайжруулах, нэгдмэл ойлголтыг бий болгох ач холбогдолтой юм. Энэхүү толь нь стратеги, хөгжлийн хөтөлбөр боловсруулах, түүнийг удирдах, хэрэгжүүлэх мөн үнэлгээг удирдан, гүйцэтгэхэд тустай хэрэглэгдэхүүн болно. Тайлбар толийг анхлан олон улсын хөгжлийн хамтын ажиллагаанд зориулан боловсруулсан боловч төрийн бодлогын аль ч салбарт хэрэглэгдэх боломжтой бөгөөд иргэний нийгэм, эрдэм шинжилгээ болон бусад ашгийн бус талбарт ч ашиглах боломжтой.

Хоёр дахь хэвлэлд, 2019 онд ЭЗХАХБ-ын Хөгжлийн тусламжийн хорооноос санал болгосон өргөн хэрэглэгддэг үнэлгээний шалгуур болох нийцтэй байдал, уялдаа холбоо, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, нөлөөлөл, тогтвортой байдлын талаарх шинэ ойлголт, шинэ ухагдахууныг багтаасан. Мөн эх хувилбарт одоогийн сайн туршлага дээр үндэслэн шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулсан болно. Ойлголт, ухагдахуун нь хөгжлийн хэрэгцээ шаардлагаар хувьсан өөрчлөгдөж байдаг тул, цаашид чухал хэрэгцээтэй үгсийг оруулж өөрчлөн, сайжруулж байх болно.